



БОЛОВСРОЛ,
ШИЖЭХЛЭХ УХААНЫ
ЯАМ



ASIAN DEVELOPMENT BANK



From
the People of Japan



Japan Fund for Prosperous and
Resilient Asia and the Pacific



ТӨРИЙН БОДЛОГЫН ШИННИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН
POLICY ANALYSIS
INSTITUTE

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ



ТЭГШ ХАМРУУЛСАН СУРГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ



БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

2022 он



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ASIAN DEVELOPMENT BANK



From
the People of Japan



JFPR
JAPAN FOREIGN POLICY RESEARCH INSTITUTE



ТОРНИЙ БОЛОВСРОЛЫН ХАМГААГАХ ТӨСӨЛ
POLICY ANALYSIS
INSTITUTE

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

ТЭГШ ХАМРУУЛСАН СУРГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Энэхүү гарын авлагыг Боловсрол, шинжлэх ухааны яам Азийн Хөгжлийн Банктай хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Япон сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй «Тэгш хамруулах боловсролыг дэмжих» төслийн хүрээнд боловсруулан хэвлүүлэв.


© Боловсрол, шинжлэх ухааны яамны зөвшөөрөлгүй хувилж, дахин хэвлэхийг хориглоно.

Боловсруулсан: Тэгш хамруулах боловсролын олон улсын зөвлөх,
Доктор Жулиа Хэйс


«Очирпринтинг» ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.
Улаанбаатар хот, 2022 он

Агуулга


ӨМНӨХ ҮГ	4-5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	6
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	7-9




СУРАЛЦАХУЙН ТҮГЭЭМЭЛ ЗАГВАРТ СУУРИЛСАН СУРГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ	10-18
---	--------------




ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИЙГ ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ НЬ	19-30
--	--------------




ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИЙГ ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ НЬ	31-40
---	--------------




СОНГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИЙГ ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ НЬ	41-50
---	--------------



ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИЙГ ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ НЬ	51-56
--	--------------



ЗАН ТӨЛӨВ, НИЙГЭМШИЛ, СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИЙГ ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ НЬ	57-68
---	--------------



СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИЙГ ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ НЬ	69-76
--	--------------

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс бол Тогтвортой хөгжлийн 4-р зорилгын хүрээнд 2030 он гэхэд бүх хүүхдэд чанартай, хүртээмжтэй тэгш боловсрол олгох үүрэг хүлээсэн дэлхийн олон орны нэг бөгөөд үүнд боловсролын үйлчилгээг бүрэн авч чадаагүй, ерөнхий боловсролын тогтолцооноос гадна, тусгаарлагдсан орчинд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах асуудал мөн хамаарна (НҮБ-ын БШУСБ, 2015).

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын ерөнхий зөвлөмж 4 – т (НҮБ, 2016) тэгш хамран сургах боловсролын асуудал бол хүн бүрийн сурч боловсрох үндсэн эрх хэмээн тодорхойлж, үндсэн зарчмуудыг дараах байдлаар томъёолсон байдаг. Үүнд: *бүх сурагчдын сайн сайхан байдлыг тэргүүлэх ач холбогдолтой хэмээн үзэж, тэдний нэр төр, төрөлхийн нандин чанар, бие даасан байдлыг хүндэтгэж, тухайн иргэний нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, хувь нэмрээ оруулах чадвар, хувь хүний зүгээс тавих шаардлагыг хүлээн авах, зөвшөөрөх зэрэг зарчмууд орно.*

Ерөнхий зөвлөмж 4-д бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцахуйг дэмжих, суралцахуйн орчныг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтойг дурджээ. Өөрөөр хэлбэл бүх шатны сургалтын байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих нэгдсэн тогтолцоо бүхий сурч боловсрох үндсэн орчин, үйл явцын төв байх ёстой гэжээ.

Цаашилбал хүүхдийн хөгжлийн ялгаатай хэрэгцээ, суралцах хурд, суралцах хэв маягт тохирсон уян хатан сургалтын хөтөлбөр, багшлахуйн болон суралцахуйн материал бүхий тохируулгат орчин бүрдсэн байх ёстой юм. Энэ орчныг бүрдүүлэхийн тулд багш, сургуулийн удирдлагуудын чадавхыг бэхжүүлж, тэдэнд дэмжлэг үзүүлэх шаардлагатайг онцолсон байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Азийн Хөгжлийн Банктай хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй **"Тэгш хамруулах боловсролыг дэмжих"** төслийн зөвлөх үйлчилгээний хүрээнд багш нарт зориулсан тэгш хамруулсан сургалтыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулсныг гарын авлагаар бэлтгэн хүргэж байна.

Гарын авлагын агуулгыг сургууль, цэцэрлэгийн багш, захирлуудын сургалтын бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн агуулга, хэлбэрээр боловсруулахын тулд зөвлөх баг төслийн зорилтот сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтнуудаас сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгааг санал асуулгын болон фокус бүлгийн ярилцлагын аргаар хийж, үр дүнд шинжилгээ хийсэн юм. Судалгаагаар багш нарт тулгарч буй нийтлэг бэрхшээл, сургалт, хөгжлийн суурь хэрэгцээг тодорхойлж, *Суралцахуйн түгээмэл загварын* үндсэн зарчимд суурилсан арга зүйн зөвлөмжийг хөгжлийн бэрхшээлийн төрөл бүрийн онцлог хэрэгцээг харгалзан боловсрууллаа. Мөн хараа, хэл яриа, харилцаа, сонсгол, хөдөлгөөн, зан төлөв, нийгэмшил, сэтгэл хөдлөл, суралцахуйн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалдаг мэргэжлийн төрийн бус байгууллага, судлаач, мэргэжилтнүүдийн төлөөллөөр хэлэлцүүлж, тэдний санал, зөвлөмжийг тусгасан болно.

Энэхүү гарын авлага тэгш хамруулах боловсролыг сургууль, цэцэрлэгийн орчинд хэрэгжүүлэхийг зорьж байгаа багш нарын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хөтөч болж, тэгш оролцоо, тэгш боломжийг бүрдүүлж ажиллахад дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн Хөгжлийн Банк
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГСТ	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө
ДБ	Дэлхийн Банк
ICF ангилал	Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
НҮБХБХЭТК	НҮБ-ын Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Эрхийн Тухай Конвенц
НҮБ-ын БШУСБ	НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага
НҮБХҮС	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сан
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХБИБ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ 4	Тогтвортой хөгжлийн зорилго 4
START	«Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах» төсөл
СТЗ	Суралцахуйн Түгээмэл Загвар
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам

ЗАРИМ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Аутизмын хүрээний эмгэг

Нийгмийн харилцаа, үгэн болон үгэн бус харилцааны алдагдал, давтагдмал зан үйлийн харилцан адилгүй түвшнээр илэрдэг хөгжлийн нийлмэл эмгэг.

Боловсролын тусгай хэрэгцээт хүүхэд

Бие бялдар, оюун ухаан, сэтгэл хөдлөл, харилцаа, зан төлөв, нийгэмшихүйн хөгжлийн хувьд нэмэлт дэмжлэг туслалцаа шаардлагатай хүүхдүүд

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө

Хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, төлөв байдлыг үнэлэн тогтоож, урт, богино хугацааны зорилго, зорилтууд, сургалтын агуулга, багшийн дэмжлэг, арга зүй зэргийн төлөвлөлт, хэрэгжилт, явцын болон эцсийн үнэлгээ хийх үйл ажиллагаануудыг нэгтгэх хөтлөх баримт бичиг юм.

Зан төлөв, сэтгэцийн бэрхшээл

Бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлөвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдцийн

улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан байдал

Харааны бэрхшээл

Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг ойлгоно.¹

Огт хараагүй – харааны бүрэн алдагдалтай/гэрлийн ямар ч мэдрэмжгүй, харааны задлан ялгах хэсэг бүрэн ажиллахгүй/,

Үлдэгдэл хараатай /нарны ба хурц гэрлийн туяаг мэдэрдэг, харааг самбараар шалгах боломжгүй, маш ойрын зайнаас хүний хурууг тоолох чадвартай, өмнөх замаа харах төдий, том овор хэмжээтэй зүйлийг ялгах төдий хараа,

Сул хараатай /холын зайд юмгүй харах чадвар, ойрын зайд юмсыг харах чадвар буурсан, төвлөрсөн болон хажуугийн юмсыг харах харааны алдагдалтай гэж ангилдаг.

1 https://mlsp.gov.mn/uploads/files/hbi_nom2020.pdf

Хөгжлийн бэрхшээлтэй хүн

Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг ойлгоно.

Хөгжлийн бэрхшээлээр үл ялгаварлан гадуурхах

Хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

Хөдөлгөөний бэрхшээл²

Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй хүнийг хөдөлгөөний бэрхшээлтэй гэж ойлгоно.

Хэл яриа, харилцааны бэрхшээл

Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг ойлгоно.

Үнэлгээ

Суралцагчийн давуу болон сул талыг илрүүлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл ажиллагаа. Энэ нь боловсролын тодорхой бодлого, зорилтын хэрэгжилтийн үр дүнг тодруулах үйл явц болдог. Үнэлгээ нь албан, албан бус, стандартчилсан, нормд суурилсан байж болдог.

Сонсголын бэрхшээл

Удамшлын болон сонсголын эрхтний гэмтэл өвчлөлийн улмаас сонсох эрхтэн үүргээ гүйцэтгэх чадваргүй болж улмаар хэл яриа нь хөгжөөгүй, дуу чимээг хүлээн авч сонсох түвшний алдагдлаас үүссэн бэрхшээл.

Суралцахуйн бэрхшээл

Танин мэдэхүйн үйл ажиллагаа (мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хадгалах, илэрхийлэх)-ны алдагдлаас шалтгаалан суралцах явцад үүсэх бэрхшээл

Суралцахуйн бэрхшээл гэдэг нь сэтгэц, мэдрэл дээр тулгуурласан танин мэдэхүйн зарим үйл явц асуудалтай байхыг хэлдэг. Үүнд мэдлэг эзэмших суурь чадварууд болох унших, бичих, тоо бодох, болон зарим нэг танин мэдэхүйн сэтгэцийн үйл явцын төрөлхийн асуудалтай байдал хамаардаг.³

² https://mlsp.gov.mn/uploads/files/hbi_nom2020.pdf

³ <https://setgelsudlal.mn/learning-difficulties/>

Суралцахуйн түгээмэл загвар

Нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг ойлгоно.

Тохирох хэрэглэгдэхүүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг ойлгоно.

Тусгай хэрэгцээт боловсрол

Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн хувийн ялгаатай байдал, тусгай хэрэгцээнд нь нийцүүлэн боловсрол эзэмшүүлэх үйл явц

Туслах хэрэгсэл

Биеийн бүтцийн гажиг, үйл ажиллагааны алдагдлыг орлох, засах, хамгаалах, дэмжих, гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг ойлгоно.

Тэгш хамран сургах боловсрол

Суралцагсдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, хэл соёл, нийгмийн гарал, эдийн засгийн хүчин зүйлсээс үл хамааран хүн бүрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх, боловсрол эзэмших тэгш боломж болон эрхийг хангахад чиглэсэн үйл явц юм (Юнеско-ийн Монголын Үндэсний комисс, 2014).

Тэгш хамран сургах тогтолцоо

Тэгш хамруулан сургах тогтолцоо нь хувь сурагчдын ялгаатай хэрэгцээнд тохируулах, тэр боломжид саад болж байгаа саад тотгорыг арилгахын тулд сургууль дахь соёл, бодлого, практик үйл ажиллагааг өөрчлөн зохион байгуулах шаардлагыг хүлээн зөвшөөрдөг.

01

Ялгаатай
хэрэгцээтэй



02

Мэдлэгийн
цар хүрээ нь
харилцан
адилгүй



03

Анхаарал
төвлөрөлт
сонирхол нь
харилцан
адилгүй



04

Хэлний
мэдлэгийн
түвшин өөр



05

Соёлын
хувьд
ялгаатай



ТЭГШ ХАМРАН
СУРГАХ
БОЛОВСРОЛЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗӨВЛӨМЖ

БАГШ НАР

САН ГАРЫН АБИЛА

1

БҮЛЭГ

СУРАЛЦАХУЙН ТҮГЭЭМЭЛ ЗАГВАРТ СУУРИЛСАН СУРГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн онцлог, сурах хэв маягийг харгалзан үзсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх нь хүч хөдөлмөр шаарддаг ажил бөгөөд сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон байдлаар боловсруулах асуудал өнөөдрийг хүртэл маргаан дагуулсан хэвээр байна. Жишээ нь, Кени болон Руанда улсад ХБХ-ийн оношинд тохируулж, тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг ч судалгааны зарим бүтээлд¹ ийнхүү тусгай хөтөлбөр боловсруулахыг төдийлөн сайшаадаггүй байна. Судлаачдын үзэж байгаагаар тусгай хөтөлбөр нь хүүхдийг бусдаас тусгаарласан орчинд сургаж, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй зөвхөн тусгай, мэргэшсэн багш нар ажиллах ёстой мэт ойлголтыг бий болгодог бөгөөд ингэснээр бусад багш нар ур чадвартаа эргэлзэхэд хүргэдэг сөрөг муу талтай ажээ.

Харин түүний оронд хүртээмжтэй сургалт, заах арга зүйн мэдлэг, ухааныг удирдлага болгож, тухайн нэг ангид зааж буй аливаа сэдвийн агуулга бүх хүүхдэд тохирсон хүртээмжтэй байх ёстой гэсэн үзэл санааг олон улсын нэртэй судлаачдын судалгааны бүтээлүүдэд дэвшүүлжээ.² Эдгээр судлаачдын үзэж байгаагаар сургуульд багшилж буй багш нар багшлахуйн арга барилаа Суралцахуйн түгээмэл загвартай уялдуулан, сайжруулах хэрэгтэй юм.

Зураг 1. Суралцахуйн түгээмэл загвар яагаад чухал ач холбогдолтой вэ

01

Ялгаатай
хэрэгцээтэй

02

Мэдлэгийн
цар хүрээ нь
харилцан
адилгүй

03

Анхаарал
төвлөрөлт
сонирхол нь
харилцан
адилгүй

04

Хэлний
мэдлэгийн
түвшин өөр

05

Соёлын
хувьд
ялгаатай

1 Флориан & Линклейтер, 2010; Хэйс, Тернбулл & Моран, 2021
2 Флориан & Спрат 2013; Уэстбрук, 2013


Суралцахуйн Түгээмэл Загвар (СТЗ) гэдэг нь хамгийн боломжит байдлаар бүх хүн хэрэглэхэд тохиромжтой, оролцоог хангасан хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдалд тохирсон загвар юм. Суралцахуйн хэв маягийн онолд суурилсан энэхүү загвар нь тодорхой нэг хэсэг сурагчдын хэрэгцээг онцлохгүйгээр боломжит бүх суралцагчийн сургалтын хэрэгцээг хангахад чиглэдэг.³

Зураг 2. Суралцахуйн түгээмэл загварын үндсэн зарчмууд



Дээрх схемээр СТЗ нь олон төрлөөр оролцоог хангах (“яагаад” суралцаж байгаа вэ буюу сурах сэдэл); **олон төрлөөр үзүүлэх** боломж олгох («юу» сурах вэ буюу мэдлэг, мэдээллийг **олон янзаар үзүүлэх**, таниулах); олон төрлөөр илэрхийлэх боломж олгох («яагаад» суралцах вэ буюу сурсан, мэдсэнээ **олон янзаар илэрхийлэх**) гэсэн үндсэн гурван зарчмын хүрээнд тодорхойлогддог болохыг харуулахыг зорилоо.

Эдгээр зарчмын хүрээнд АНУ-ын Тусгай технологийн хэрэглээний төв 9 удирдамж, сурагчдын олон талт хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх судалгаанд суурилсан практик зөвлөмжүүдийг багтаасан 31 удирдамж бүхий эмхэтгэлийг боловсруулсан байдаг.⁴ Энэхүү загвар нь “зарим хүнд чухал” зүйл бараг «бүх хүнд сайн» зүйл байдаг гэсэн гол санаанд суурилдаг.⁵



3 CAST, 2018; UNICEF & Johnstone, 2014

4 Холл, Мейер, & Поуз, 2012.

5 Meyer et al., 2014.

1.1. Сургуулийн түвшинд СТЗ-н гурван зарчмыг хэрэглэх нь

Нэг ангид суралцаж буй хүүхэд бүр хүсэл сонирхол, ур чадвар, хүйс, гэр бүлийн орчин, мэдлэг туршлагын хувьд харилцан адилгүй байдаг. Иймд хүүхэд бүрд тохирсон нэг хэв загварын багшлахуйн арга барил байх боломжгүй юм. Харин СТЗ-ын гурван зарчмыг хэрэгжүүлснээр багш хичээлийг илүү хүртээмжтэй, хүүхдийн тэгш оролцоог бүрэн хангасан хэлбэрээр заах боломж бүрддэг.

- **Сэдэлжүүлэх замаар оролцоог хангах арга замууд: “Яагаад” суралцаж байгаа вэ?: Хүүхдийн сурах сэдэл**

Сурагчид өөрийнх нь сонирхол, хүсэл эрмэлзэлд нийцсэн хичээлд идэвхтэй, тууштай оролцох хандлагатай байдаг тул багш багшлахуйн болон суралцахуйн үйл явцыг олон арга замаар сурагчдыг сэдэлжүүлж, оролцоог хэрхэн хангах вэ гэдэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй. (Pereira et al., 2018). Хүүхдийн мэдлэг туршлага, суурь боловсрол, ар гэрийн байдал нь тухайн хүүхэд “яагаад” суралцаж байгаа вэ гэдэгт ихээхэн нөлөөтэй байдаг учраас багш сурагчдын амьдралд ойр, бодит нөхцөл байдалд тулгуурласан арга барилаар ажиллах нь чухал байдаг. Хэдийгээр ижил сургалтын хөтөлбөрөөр хичээллэдэг ч хөдөө, орон нутагт амьдарч буй хүүхдийн сурах сэдэл хотод амьдардаг сурагчийнхаас ялгаатай байж болно. Гэвч хөдөө амьдардаг сурагч хотын амьдрал, нөхцөл байдлыг сонирхох, эсрэгээрээ хотын сурагч ч ялгаагүй хөдөөгийн амьдралыг сонирхдог байж болох учраас багш нар суралцагчдын нийтлэг хүсэл сонирхлыг харгалзан үзэхийн зэрэгцээ сурагч бүрийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн хэлбэрээр хичээлээ заах хэрэгтэй.

- **Мэдлэг мэдээллийг олон хэлбэрээр үзүүлэх арга замууд: Хүүхэд “юу” сурч байгаа вэ?**

Хүүхэд бүр багшийн заасан хичээлийг өөр өөрийнхөөрөө ойлгох боломжтой. Жишээлбэл, хараа, сонсголын бэрхшээл; суралцахуйн бэрхшээлтэй, хэл яриа болон нийгэмшихүйн бэрхшээлтэй хүүхдүүд аливаа мэдээллийг өөрийн гэсэн онцлог арга барилаар хүлээж авдаг. Харааны болон сонсголын бэрхшээлгүй зарим суралцагч хэвлэмэл материалаас илүү хараа болон сонсголоороо дамжуулан мэдээллийг хурдан ойлгож болно. Ийм боломж маш олон хувилбартай байж болох учраас сурагчдад мэдээллийг аль болох олон сонголттой хэлбэрээр үзүүлэх боломж олгосноор хүүхдүүд мэдээллийн агуулгын мөн чанар болон агуулга хоорондын холбоог ойлгох боломж бүрддэг. Ийм болохоор суралцахад учирч буй саад бэрхшээлийг багасгахын тулд багшийн хичээл зааж буй арга барил бүх хүүхдийн мэдээлэл хүлээж авах онцлогт тохирсон сонголттой байх ёстойг багш бүр бодолцоорой гэж зөвлөө. Үүний тулд:

- 1) ижил мэдээллийг олон хэлбэрээр хүргэх (хараа, сонсгол, хүрэлцэхүйн хүртэхүйгээр дамжуулж г.м);
- 2) мэдээллийг хүлээн авагч өөрөө сонгож тохируулах боломжтой хэлбэрээр мэдээлэл өгөх (текстийг томруулах, дууг өсгөх боломжтой байх г.м).

Ийнхүү мэдээллийг олон хэлбэрээр үзүүлж, дамжуулах нь дан ганц хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах үйл явцыг дэмжиж байгаа хэрэг биш бөгөөд бусад сурагчдын мэдээлэл хүлээн авах, ойлгох хэрэгцээг хамтад нь харгалзан үзсэн зарчим юм.

• **Үйлдэл хийх, түүнийгээ илэрхийлэх арга замууд: Хүүхэд “хэрхэн” суралцаж байгаа вэ?**

Хүүхэд бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг. Жишээлбэл, хүнд хэлбэрийн хөдөлгөөний бэрхшээлтэй, харилцааны бэрхшээлтэй хүүхэд аливаа дасгал даалгаврыг бусадтай адил ойлгож, гүйцэтгэх боломж хомс байдаг. Зарим сурагч өөрийгөө бичгээр илэрхийлэхдээ сайн бол бусад нь хэл яриагаараа илүү сайн илэрхийлдэг.

Харааны бэрхшээлтэй хүүхдэд үзэг харандаа бариулаад бичгээр шалгалт авбал тухайн хүүхэд сурсан мэдсэнээ хангалттай хэмжээнд илэрхийлж чадахгүй байж болно. Хэрэв багш тухайн хүүхдийн бичгийн чадварыг үнэлэхийг зориогүй бол өөр ямар нэг аргаар өөрийгөө илэрхийлэх боломж олгох ёстой. Хичээлийн агуулга, сэдвийн талаар юу сурснаа илэрхийлэх олон төрлийн арга барилыг зааж өгснөөр хүүхэд бүр өөрийн онцлог, ур чадвартаа тохируулан өөрийгөө илэрхийлэх боломж бүрдэнэ.⁶

Хэдий СТЗ-ын үндсэн зарчмуудтай уялдсан арга барил нь тусгайлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулагдаагүй боловч бүх хүүхдийн суралцах үйл явцад дэмжлэг үзүүлдэг. Доорх хүснэгтэд энэхүү СТЗ-ын арга барил, уламжлалт заах арга барилаас хэрхэн ялгарч, тэгш хамруулах соёлыг дэлгэрүүлдэг болохыг тайлбарлалаа.

6 Хэйс, Тернбулл ба Моран, 2018

Хүснэгт 1: Уламжлалт арга барил ба суралцахуйн түгээмэл загварын ялгаа

Уламжлалт багшлахуйн загвар	СТЗ-ын зарчимд үндэслэсэн багшлахуйн загвар
<p>Юу заахад хичээлийн зорилго төвлөрдөг.</p> <p>Сурагчдад ямар агуулгатай хичээл заах вэ гэдэгт гол анхаарлаа хандуулдаг. Хичээлүүд «ердийн» сурагчдад зориулагдсан учир багш хичээлийг нэг л байдлаар бүх ангийн сурагчдад хүргэнэ. Жишээлбэл, багш Монголын хаадын талаар түүхийн хичээл заахдаа тэдний нэрийг, он сартай нь самбар дээр бичээд, сурагчид хуулж бичдэг.</p>	<p>Юуг, хэрхэн заахад хичээлийн зорилго төвлөрдөг.</p> <p>Багш сурагчдынхаа суралцах хэв маяг, чадвар, онцлог хэрэгцээнд тохируулж хичээлээ бэлтгэж, олон хувилбараар заана. «Ердийн» сурагч гэсэн ойлголт байхгүй. Хичээлийн удиртгал хэсгийг уламжлалт маягаар заасан ч товч бичвэрийг тайлбартай дүрс бичлэгтэй хамт үзүүлж болно. Мөн сурагчдаар Монголын хаадын давуу болон сул талыг харьцуулан харуулах тоглоом тоглуулах гэх мэт олон хувилбар байж болно.</p>
<p>Тусгай боловсрол хэрэгцээтэй хүүхдэд зориулж тохируулга хийдэг.</p> <p>Зөвхөн ГСТ хэрэгжиж буй хүүхдэд зориулж, суралцахуйн үйл явцыг дэмжин ангийн нөхөдтэйгөө ижил агуулга судлах үүднээс тохируулга, өөрчлөлт хийдэг. Жишээ нь ГСТ хэрэгжиж байгаа хүүхдэд хэвлэмэл номыг аудио хэлбэрт хувирган өгөх нь ангийн бүх сурагчдад хүртээмжгүй байж болно.</p>	<p>Бүх сурагчдын хэрэгцээг харгалзаж, тохируулга хийдэг.</p> <p>Үүнтэй ижил тохируулга, өөрчлөлтийг ангийн бүх хүүхдийн хэрэгцээ шаардлагад тохируулж хийнэ. Учир нь хичээлийг олон хэлбэрээр хүргэх нь бүх хүүхдийн нийтлэг хэрэгцээг хангаж байна гэсэн үг. Түүнчлэн, энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусдаасаа тусгаарлагдах эрсдэлийг бууруулдаг.</p> <p>Жишээ нь багш тухайн сэдвийг заахдаа ном ашиглаж байвал номыг бүгдэд хүртээмжтэй байдлаар, Брайль, онлайн эсвэл том үсгийн бичвэртэй зэрэг олон хэлбэрээр өгч болно.</p>
<p>Тогтсон ангийн зохион байгуулалттай</p> <p>Уламжлалт ангид ширээнүүд байрлалаа өөрчлөхгүйгээр эгнэн байрлаж, багш самбарын өмнө гарч бүх хүүхдэд хандсан байдалтайгаар хичээлээ заах нь элбэг тохиолддог.</p>	<p>Уян хатан ангийн зохион байгуулалттай</p> <p>Сурагчид бие даан чимээгүй орчинд хичээллэх, бүлгээр ажиллах, ангиараа хамтран хийх зэргээр олон төрлийн үйл ажиллагаанд зориулж анги танхимын зайг өөр өөрөөр зохиомжилж болох, уян хатан зохион байгуулалттай байдаг. Сурагчдын ялгаатай хэрэгцээ, хичээлийн агуулга зэргээс хамаарч багш ангийн аль ч хэсэгт чөлөөтэй зорчих боломжтой байх нь чухал.</p>
<p>Сурагчдын мэдлэг ойлголтыг үнэлэх нэг арга барилтай</p> <p>Сурагчид сурсан мэдсэнээ нэг л төрлийн шалгаж, хянах арга барилаар илэрхийлдэг. Жишээ нь номын тэмдэглэл хөтлөх даалгаврыг зөвхөн эсээ байдлаар бичүүлж авах, шалгалт авах г.м</p>	<p>Сурагчдыг үнэлэх олон төрлийн үнэлгээний арга барилтай</p> <p>Сурагчид өөрсдийн мэдлэг чадвар, хөгжлийн ялгаатай түвшнээс шалтгаалж сурсан мэдсэнээ өөр өөр арга хэлбэрээр илэрхийлэх боломжтой. Жишээ нь, сурагчид бичсэн номын тэмдэглэлээ бичлэг, танилцуулга, эсээ зэрэг өөрт тохирсон байдлаар үзүүлэх сонголттой.</p>
<p>Дүнгийн амжилтаар суралцагчийн гүйцэтгэлийг хэмждэг</p> <p>Суралцагчид шалгалт, асуулт хариулт, төслийн даалгаврын гүйцэтгэлээр багшаас дүн авдаг ч энэ нь зорилгодоо хүрэх, үр дүнтэй суралцах үйл явцын нэг хэсэг тэр бүр болж чаддаггүй.</p>	<p>Дүнгийн амжилтыг тавьсан зорилгодоо хүрэх алхам гэж үздэг.</p> <p>Сурагч багшаас үнэлгээ, санал, зөвлөмж авч түүнийгээ суралцах үйл явц, зорилго чиглэлдээ тусгадаг.</p>

Багш хүн СТЗ-ын эдгээр зарчмуудыг багшлахуйн арга барилтайгаа хослуулснаар зорилгодоо хүрэх олон арга замыг сурагчдадаа нээн өгч, суралцахуйн аливаа асуудалд уян хатан хандах боломж бүрдэх болно.

1.2. Хүүхдийн бэрхшээлийн оношилгоо, ангиллыг мэдэхээс илүүтэй тухайн хүүхэд өдөр тутмын үйл ажиллагаанд оролцоход ямар бэрхшээлтэй тулгарч буйд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээг танин мэдэх хэрэгцээ өндөр байгааг багш нараас авсан судалгааны үр дүн батлан харуулж байна.⁷ Үүнийг үндэс болгож энэхүү гарын авлагад багш нарт СТЗ-ын зарчимд суурилсан сургалтын хөтөлбөрийн арга зүйн зөвлөмжийг тодорхой жишээ баримтад үндэслэн тайлбарлав. Чингэхдээ хөгжлийн бэрхшээлийн төрөл болон оношилгоонд ач холбогдол өгөхөөсөө илүү олон улсад хөгжлийн бэрхшээлийг тодорхойлоход өргөн хэрэглэдэг Вашингтон бүлгийн арга барилыг ашиглах нь зүйтэй гэж үзсэн болно. Энэ бол тухайн хүүхэд өдөр тутмын үйл ажиллагаанд оролцоход ямар бэрхшээлтэй тулгарч байна гэдгийг гол шалгуур болгон авч үздэг аргачлал юм. Хэрэв бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээг авч үзэхдээ дан ганц оношилгоонд суурилбал адилхан бэрхшээлийн оноштой хүүхэд бүр адил хэрэгцээ, дэмжлэг туслалцаа хэрэгтэй болно гэсэн дүгнэлтэд хүрэх магадлалтай. (Жишээ нь: Дауны синдром бол бусад бэрхшээлтэй огт адилгүй байдаг) Мөн албан ёсоор оношлогдоогүй ч өдөр тутамдаа тодорхой хэмжээний бэрхшээлтэй учирдаг хүүхдүүд дэмжлэг туслалцаанаас орхигдох тохиолдол цөөнгүй байна. Түүний оронд багш нар хүүхдүүдээ ажиглаж ямар хүндрэл бэрхшээл тулгарч байна вэ гэдэгт анхаарлаа зүй ёсоор хандуулах илүү хүртээмжтэй гэдгийг зөвлөж байна. Багш хүн багшлахуйн үйл явцдаа дараах төрлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах хэрэгцээ шаардлага гарч болно.

- o Хараа
- o Сонсгол
- o Суралцахуй
- o Ярих, харилцах
- o Хөдөлгөөн
- o Зан төлөв, нийгэмшил болон сэтгэл хөдлөл

Зарим багшийн хувьд хараа, сонсгол, харилцаа болоод хөдөлгөөний огт чадамжгүй хүүхэдтэй ажиллах хэрэгцээ шаардлага ч тулгарч болно. Үйл ажиллагааны бэрхшээлийг илүү чухалчлан анхаарна гэдэг бол тухайн хүүхэдэд онош тавих эсвэл оношийг өөрчилнө гэсэн үг огтхон ч биш ээ. Харин хүүхэдэд суралцахуйн явцад ямар

7 АХБ, БШУЯ "Тэгш хамруулах боловсролын дэмжлэг төсөл", Багш нарын сургалтын хэрэгцээний тайлан, 2022

хүндрэл бэрхшээл тулгарч буйг багш мэдсэнээр тухайн хүүхдийг практик арга зүйгээр дэмжиж боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх болно. Жишээлбэл, аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэд нэгэн зэрэг суралцахуйн, хэл ярианы, харилцааны, зан төлөвийн бэрхшээлтэй тулгарч байхад өөр нэг аутизмтай хүүхэд зөвхөн зан төлөв болоод нийгэмшлийн асуудалтай тулгарч байх гэх мэтээр янз бүрийн тохиолдол гардаг. Тиймээс энэ төрлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүйг багш нарт ойлгуулж зааж чадвал адилхан аутизмтай ч тэдний ялгаатай онцлог хэрэгцээнд тохируулан багшилж, мөн харилцаа, зан төлөв зэрэг бусад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйн үйл явцыг дэмжих бүрэн боломжтой юм.

Ангийн сурагчид бие биедээ туслах замаар суралцахуйг дэмжих

Нэг ангид хэтэрхий олон хүүхэд суралцаж байгаагаас үүдэн багш бэрхшээлтэй хүүхдэд тусгайлан цаг гаргаж, хичээлээ заах боломж хязгаарлагдмал байдаг. Багш энэ тохиолдолд ангийн нөхөд нь бэрхшээлтэй хүүхдэд тусалж, бие биеэсээ суралцдаг эерэг сургалтын орчин бүрдүүлэхэд анхаарлаа хандуулах нь зүйтэй. Жишээ нь:

- Ангид сонсголын бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа тохиолдолд

Хэрэв бэрхшээлтэй хүүхэд багшийн ярьж буй зүйлсээс ямар нэг зүйл сонсохгүй орхигдуулбал сонсголтой найз нь түүнийг нь давтан хэлж өгч тусалж болно. Ингэснээр бэрхшээлтэй хүүхэд заавал багшийн дэмжлэгийг хүлээлгүйгээр найзаасаа тусалцаа авч, дасгал даалгавраа хийж гүйцэтгэх боломжтой.

- Ангид харааны бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа тохиолдолд

Ангийн нөхөд нь харааны бэрхшээлтэй хүүхдэд тэмдэглэл хөтлөх, нэг хичээлээс нөгөөд шилжих, анги солиход нь туслах, хичээлээс ойлгоогүй үлдсэн зүйл байвал дахин тайлбарлаж өгөх зэргээр туслах боломжтой. Ингэхдээ дараах алхмуудыг баримтлаарай.

1. Эхлээд тухайн хүүхдээс тусламж хэрэгтэй эсэхийг нь асууж, шаардлагатай тохиолдолд туслаарай. Харааны бэрхшээлтэй хүүхэд таны гарын тохойноос үл ялиг дээр буюу гарын булчин хэсгээс барина. Хэрэв бүр бага насны хүүхэд байвал бугуйнаас тань барьж болно. Зөвхөн эцэг эх, найзууд нь бэрхшээлтэй хүүхдийн гараас атгаж болдог.
2. Хараатай хүн харааны бэрхшээлтэй хүүхдээс ямагт хагас алхмын өмнө явна. Хэрэв нарийн замаар явах хэрэгтэй болбол хөтөлж буй гараа ардаа гаргаад тухайн хүүхэд таны араас алхах нь зүйтэй.



2

БҮЛЭГ

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ
СУРАЛЦАГЧИЙГ ТЭГШ ХАМРУУЛАН
СУРГАХ НЬ

2.1. Харааны бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт

Харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд хэр их зүйлийг ямар түвшинд харж чадаж байгаагаас хамаарч бэрхшээлийн хэлбэр харилцан адилгүй байна. Хэрэв юу ч харахгүй эсвэл маш хязгаарлагдмал хүрээнд харж байвал тухайн хүүхдийг хараагүй гэж тооцох бол тодорхой хэмжээнд харж чадах ч энгийн хараатай хүүхдээс дутуу харж байвал сул хараатай хүүхэд гэж үздэг. Өөрөөр хэлбэл, харааны бэрхшээлийг үндсэн хоёр төрөлд ангилж болно. *Нэгдүгээрт*, бүрэн хараагүй буюу огт юу ч харахгүй, *хоёрдугаарт*, сул хараатай буюу үлдэгдэл хараатай гэж ангилна. Энэ ангиллыг мэргэжлийн эмч тодорхойлох шаардлагатай. Харааны үлдэгдэл байдал ямар байна гэдгийг зөв тодорхойлсноор тухайн хүнд ямар сургалтын орчин, ямар сургалтын хэрэгсэл хэрэгтэй гэдэг нь тодорхой болно. Харааны байдлыг зөв тодорхойлох нь хараагүй хүүхдэд сургалт явуулахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай зүйл байдаг.

Сул хараатай хүүхдийн хувьд ямар өнгийг сайн харж ялгаж байгааг нь тодорхойлоод тухайн өнгөөр бичигдсэн тод өнгийн зүйлс, дүрс, ямар хэмжээнд, ямар зайнд тухайн дүрс, эд зүйлийг харж байгаад тохируулж тухайн хүүхдийн суралцах үйл явцад ашиглах шаардлага гарна.

Хэрэглэгдэхүүн: Сул хараатай бол самбарын болон ангийн хаана суулгах гэдгийг шийдэхээс гадна ямар өнгөтэй, ямар дүрсийг харуулах, ямар төхөөрөмж ашиглах гэдгээ хүүхдийн харааны онцлогоос шалтгаалан тодорхойлдог.

Тохируулга: Өнгөний хараа муутай хүүхдийн сурах үйл явцыг ямар өнгийг илүү тод харж байгаагаас нь шалтгаалан тохирох өнгийг сургалтад ашигладаг. Мөн гэрэл багатай үед тод хардаг хүүхдийг цонхны, нарны гэрэлтэй ойрхон газар суулгах нь тохиромжгүй. Тийм хүүхдийг цонхны эсрэг, ханан талд суулгах, эсрэгээрээ гэрэл шаардлагатай хүүхдийг тод гэрлийн доор, эсвэл ангийн цонхны дэргэд гэрэлтэй газрыг сонгон суулгах шаардлагатай.


Мөн харах хүрээ алдагдсан тохиолдол байдаг. Нүднийхээ дунд хэсгээр, дээд, доод, хажуу хэсгээр хардаг хүүхдүүд байдаг. Жишээлбэл, нүднийхээ зүүн гар талын хэсгээр хараад төв хэсэг, баруун гар талын хэсгээр огт харахгүй хүүхэд байвал зүүн гар талын хананд суулгах нь тохиромжтой. Энэ тохиолдолд хүүхэд толгойгоо бага зэрэг баруун тийш эргүүлээд чигээрээ самбар дээр



байгаа зүйлийг төвөг багатай харах боломжтой болдог. Тэгэхээр харааны хүрээ алдагдсан тохиолдолд хүүхэд аль хэсгээрээ сайн харж байгаагаас шалтгаалан тухайн хүүхдийг ангийн аль хэсэгт суулгахаа багш тодорхойлно. Эдгээр зүйлсийг харааны бэрхшээлтэй хүүхдийг сургах үйл явцад анхаарах шаардлагатай байдаг.

Тухайн хүүхдийн ангид сууж байгаа байрлал, гэрэл, сургалтын хэрэглэгдэхүүн, тэдгээрийг ашиглах хэлбэр, багшийн яриа маш тодорхой хүн заавал харж байж ойлгохуйц биш, ойлгомжтой байх шаардлагатай.

Харааны бэрхшээлтэй хүүхдийн суралцах үйл явцыг дэмжих, орчны тохируулгыг хийхэд анхаарах нэг чухал зүйл бол явган хүний зам дээр чиглүүлэгч, товруут зам хийх байдаг. Энэ зам стандартын дагуу байх шаардлагатай. Зарим тохиолдолд зам хийсэн хэдий ч явж байгаад алга болох, дуусах тохиолдол байдаг. Ийм стандартын шаардлага хангаагүй зам бол хараагүй хүүхэд зорчиход маш аюултай орчин байдаг. Тэгэхээр стандартыг маш сайн мөрдөх шаардлагатай. Мөн замын хөдөлгөөний зохицуулах гэрэл дохио дуутай байх ёстой. Сургуулийн хаалганаас эхлээд дуут дохио, сургууль дотроо хананы чиглүүлэгч бариул, анги бүрийн үүдэнд хүүхэд гараараа тэмтэрч унших боломжтой өндөрт, брайл болон кирилл үсгээр тод бичсэн байх шаардлагатай байдаг. Сургалтын орчинд наад зах нь дээрх тохируулгат орчныг бий болгож байж харааны бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхдийн адил бие дааж, аюулгүй суралцах ерөнхий орчин, нөхцөл бүрддэг.



Бүрэн хараагүй хүүхдэд сургалт явуулахад товгор бичиг, үсэгнээс эхлээд сургалтын хэрэглэгдэхүүнийг биет байдлаар бэлтгэх хэрэгтэй болдог.

Сул хараатай хүүхэд зөвхөн ойрын зайд байрлах эд юмсыг (*жишээ нь ном*), эсвэл холын зайд байрлах зүйлийг ялгаж харах чадвартай байдаг (*жишээ нь самбар*).

Харааны бэрхшээлтэй хүүхэд тулж харилцах чадвар, хүний сэтгэлийн өнгө аясыг харж мэдрэх, харилцаагаа тухайн нөхцөлд зохицуулах мэдрэмж дутуу, утга санааг илүү тусгадаг учир мэдрэмтгий харьцдаг.

Тодорхой зарим нөхцөл байдлаас шалтгаалан хүүхдийн харааны төвийн үйл ажиллагаа алдагдсан байдаг. Төв харааны тусламжтайгаар хүүхэд ном унших, самбар дээр бичсэн зүйлийг харах зэрэг нүдний чанх урд байрлаж буй зүйлсийг харах боломжтой болдог. Төв хараагаа алдсан хүүхэд аливаа зүйлсийг захын хараагаараа харах гэж хичээдэг учир хүүхдийн толгой үргэлж нэг тал руу далийж байдаг. Харин зарим эмгэгийн улмаас хүүхэд захын хараагаа алдах тохиолдол бий. Захын хараа нь харааны төв хэсэгт харагдах талбайд өртдөггүй буюу бидний эргэн тойронд байгаа орчин, нүдний булангийн зай талбайг харахад тусалдаг. Мөн хөдөлгөөнийг барьж авах чадвар сайн байдгийн дээр харанхуй, бүүдгэр орчинд харах чадвар өндөр тул хүүхэд ангид эсвэл тоглоомын талбайд гүйх, хөдлөхөд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг байна. Харин төв хараа шиг аливаа юмсыг нарийвчилж харж чаддаггүй. Захын харааны алдагдлыг хонгилын хараа гэж нэрлэдэг бөгөөд эргэн тойрноо харж чадахгүй, зөвхөн хонгилоор харж буй мэт нүдний урд талбайг чигээрээ хардаг учир ийнхүү нэрлэжээ. Түүнчлэн захын харааны алдагдалтай хүүхдүүд хөдөлгөөн хийхдээ маш болгоомжтой ханддаг. Мөн зарим тохиолдолд харааны тасалдал үүсэж болно. Тиймээс багш Та харааны бэрхшээлтэй хүүхдийг сайтар ажиглаж, нягт нямбай анхаарч байхаас гадна эцэг эхтэй нь ярилцаж хүүхэд ямар бэрхшээлтэй тулгарч байгааг маш сайн тодруулж авахыг хичээгээрэй.

Харааны бэрхшээлтэй зарим хүүхэд нийгмийн харилцаанд ороход хүндрэлтэй байдаг. Хүүхэд бусадтай харилцаж чадахгүй, өөрийгөө хязгаарладаг бол зарим нь үе тэнгийнхээ хүүхдүүдийг хангалттай хэмжээнд харж чаддаггүй учраас тэдний үйл хөдлөл, дохио зангааны утга агуулгыг сайн ойлгодоггүй. Гэхдээ иймэрхүү асуудлыг багш суралцахуйн үйл явцаар дамжуулан шийдэх бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл, харааны бэрхшээлтэй сурагчид нийгмийн харилцаанд оролцох, үе тэнгийнхэнтэйгээ ижил хэмжээнд суралцах боломж бий гэдгийг эрхэм багш Та бүхэн манай гарын авлагаас ойлгоно гэдэгт найдаж байна.

- Харааны байдлыг зөв тодорхойлох
- Маш оновчтой арга зүй, тухайн хүүхдэд хэрэгцээтэй хэрэгслүүдийг ашиглан сургалтыг явуулах
- Сургалтын орчин болон гэрээс сургууль хүрэх орчныг хүртээмжтэй, аюулгүй байдлаар бүрдүүлэх шаардлагатай.

Энэ зорилгоор багш нар харааны бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүй, аргачлалуудын талаар одоо дэлгэрүүлж үзэцгээе.

2.2 Харааны бэрхшээлтэй хүүхдүүдийг сэдэлжүүлж, оролцоог хангах арга замууд

Суралцагчдын сурах сэдэл харилцан адилгүй учир багш хүүхдийн суралцах үйл явцад оролцох боломжийг аль болох олон арга замаар хангахын төлөө багш хүн ажиллах ёстой байдаг.

Харааны бэрхшээлтэй хүүхдийн сурах үйл явцад тулгарах хүндрэлүүд



Бие эрхтний өсөлт болон оюуны хөгжлөөр хоцрох



Ерөнхий хөдөлгөөн хязгаарлагдах



Өөртөө болон амьдралд итгэл алдах



Зан харилцаа сэтгэлийн хөдөлгөөнд өөрчлөлт орох



Харааны мэдрэмж буурах, алдагдах



Бичгийн чадвар сул



Гадаад байдалдаа хяналт тавих чадвар сул байдаг

Эх сурвалж: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхчүүдийн холбоо. <https://apdc.mn>.

Энэ ажилд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор тус төслийн хүрээнд хийсэн сургалтын хэрэгцээний үнэлгээний дүн болон олон улсад нийтлэг хэрэглэдэг арга зүй, аргачлалыг үндэс болгон дараах товч зөвлөмжийг боловсруулав.

Харааны бэрхшээлтэй хүүхдийн суралцах үйл явцыг сэдэлжүүлэх, оролцоог хангах олон аргууд байдгаас энд Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж буй багш нартаа санаа өгөх үүднээс зарим аргуудын талаар товч авч үзье. Үүнд:



Хүүхдийн сонирхол, чадвар чадамжид тулгуурлан хичээлээ заах

Харааны бэрхшээлтэй хүүхдүүд юуг, ямар байдлаар сонирхох нь хүүхдийн онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байх тул багш тухайн хүүхдийн сонирхолд нийцсэн байдлаар арга барилаа сонгож, шаардлагатай тохиолдолд өөрчилж байх хэрэгтэй. Энэхүү шинэлэг арга барил нь харааны бэрхшээлтэй хүүхдэд тохирсон байхаас гадна тухайн ангийн бүх суралцагчийн нийтлэг хэрэгцээг харгалзсан байх нь чухал. Зарим сурагч шинэ, шинэлэг санаачилгад дуртай байдаг бол зарим нь тогтсон хэв загвараар суралцахыг илүүд үздэг. Үүнтэй адил зарим сурагч ганцаараа хичээллэхийг илүүд үздэг бол бусад нь багийн ажилд идэвх, санаачилгатай оролцдог байх жишээтэй. Мэдээж бүх суралцагчийн нөхцөл байдалд тохирсон тэдний оролцоог хангах тогтсон, оновчтой загвар гэж үгүй (CAST, 2013). Харин багш хүүхдийнхээ хэрэгцээ

сонирхлыг танин мэдэж, өөртэй нь болоод эцэг эхтэй нь ярилцаж, зөвлөлдсөнөөр хамгийн үр дүнтэй суралцахуйн аргыг хамтдаа олж тодорхойлж болно.

Хэн ярьж буйг хүүхдэд мэдэгдэх



Хүүхэд ангийнхныхаа нэг хэсэг болсноо мэдэрсэн үедээ, мөн нэг ангид өөртэй нь хамт ямар хүмүүс байгааг мэдсэн үедээ хичээлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож эхэлдэг байна. Хэрэв ангид хараагүй хүүхэд байвал багш өөрийгөө танилцуулаад, өөр ямар хүмүүс ангид байгааг танилцуулах хэрэгтэй бөгөөд тухайн хүүхэдтэй харилцах бүртээ нэрээр нь дуудаж, өөртэй нь ярьж буй гэдгээ мэдэгдээрэй. Ингэснээр харааны бэрхшээлтэй хүүхэд бүр өөрийгөө ангийнхаа хамт олны нэг гишүүн болсныг ойлгож, суралцахуйн үйл явцад идэвхтэй оролцох болно.

Харааны бэрхшээлтэй хүүхдийн харах талбайг хамгийн их байхаар тооцож, багш байрлалаа болон бичих арга барилаа тохируулах



Юуны өмнө, багш өөрийнхөө араас нарны хурц гэрэл тусах газар зогсож хичээлээ тайлбарлахаас зайлсхийх хэрэгтэй. Учир нь хурц гэрэл харааны бэрхшээлтэй хүүхдийн хувьд багшийн царайг харах боломжийг хязгаарладаг. Хараагүй хүүхэд багшийн самбар дээр бичсэн зүйлийг уншиж чадахгүй. Харин сул хараатай сурагчид самбар дээрх бичгийг уншихын тулд нэлээд хүндрэлтэй тулгарна. Иймд багш самбарт бичих үедээ нэг удаа, бичиж дууссаныхаа дараа дахин нэг удаа юу бичсэнээ давтан уншиж өгөөрэй.

Хэрэв багш Та самбар ашиглан хичээл зааж байгаа бол дараах зүйлүүдэд анхаараарай.





Сурагчдын суудлыг хуваарилах

Харааны бэрхшээлтэй хүүхдийг самбарын урд суулгах нь зөв. Тухайн хүүхдэд тусгаарлагдаж буй мэт мэдрэмж төрүүлэхгүй байх үүднээс ширээний найз нь хараатай хүүхэд байх хэрэгтэй. Түүнчлэн бүлгээр ажиллах үед хүүхэд чөлөөтэй суудлаа сольж суудаг байх хэрэгтэйг бодолцоорой.

Ангийн хаалга болон сул хараатай хүүхдийн ширээ, сандал дээр тод өнгийн наалт наавал тухайн хүүхэд хурц ирмэг, өнцөгтэй зүйлсийг илүү сайн харах боломжтой болно. Мөн ариун цэврийн өрөө харааны бэрхшээлтэй хүүхдэд хүртээмжтэй, цэвэрхэн, ашиглахад хялбар байх хэрэгтэй ба анги танхим, суудал хуваарилах зэрэгт өдөр бүр анхаарч байх хэрэгтэй.



Нам гүм, чимээгүй орчинд хичээл хийх боломж олгох

Харааны бэрхшээлтэй хүүхэд бусдын адил суралцахын тулд сонсголын мэдрэхүйгээ түлхүү ашигладаг онцлогтой. Иймд тухайн хүүхдийн суралцаж буй ангийн орчин нам гүм, чимээ, шуугиангүй байх шаардлагатай. Ийм орчин бол зөвхөн сонсголын бэрхшээлтэй хүүхдэд төдийгүй тухайн ангид суралцаж буй бүх хүүхдэд хичээлээ анхааралтай хийх таатай орчин болдог. Хичээлийн үеэр чимээ анир багатай, нам гүм орчин бүрдүүлэхэд багшаас гадна тухайн ангийн сурагчид нийтээрээ оролцох ёстой гэдгийг багш анхаарч, сурагчдадаа ойлгуулах нь үр дүнтэй гэдгийг зөвлөө.



Хичээлээ тэмдэглэх, нэг хичээлээс нөгөөд шилжихэд ангийн найз нөхөд нь тусалдаг байх ёстой

Нэг анги суралцаж байгаа бусад сурагчид харааны бэрхшээлтэй хүүхдэдээ тэмдэглэл хөтлөх, нэг хичээлээс нөгөөд шилжих, хүртээмжтэй хэлбэрээр суралцахад нь тусалдаг найзын системийг бий болгох ажлыг зохион байгуулаарай. Ингэхдээ дараах алхмуудыг баримтлах шаардлагатайг анхаарна уу.

1. Эхлээд тухайн хүүхдээс тусламж хэрэгтэй эсэхийг асуух ёстой. Хэрэгтэй тохиолдолд туслаарай. Харааны бэрхшээлтэй хүүхэд таны гарын тохойноос үл ялиг дээр буюу гарын булчин хэсгээс барина. Хэрэв бүр бага насны хүүхэд байвал бугуйнаас тань барьж болно. Зөвхөн эцэг эх, найзууд нь бэрхшээлтэй хүүхдийн гараас атгана гэдгийг санаж байх ёстой.
2. Хараатай хүн харааны бэрхшээлтэй хүүхдээс ямагт хагас алхмын өмнө явна. Хэрэв нарийн замаар явах хэрэгтэй бол хөтөлж буй гараа ардаа гаргаад тухайн хүүхэд таны араас алхах учиртай.

3. Шатаар явахдаа өгсөж эсвэл уруудаж буйг хүүхдэд хэлж, түүнийг шатны бариул руу чиглүүлж туслаарай.

Дунд болон ахлах сургуулиудад коридорын ачаалал багатай үед харааны бэрхшээлтэй хүүхдийг хичээл дуусахаас 5 минутын өмнө засварлахыг зөвшөөрөх нь зүйтэй.




Орон зайн баримжаа, хөдөлгөөний ур чадварт сургах

Хараагүй болон сул хараатай хүүхдийн аль алинд нь орон зайн баримжаатай болох, түүндээ нийцсэн хөдөлгөөний ур чадварт суралцах хэрэгцээ их байдаг. Орон зайн баримжаатай болох гэдэг нь хүүхэд хаана байгаагаа, хаашаа явахаа, ямар замаар явахаа мэдэж байна гэсэн үг. Харин хөдөлгөөн нь хүүхдийг хүссэн газарт нь очиход тусалдаг чадвар юм. Ийм чиглэлээр зохион байгуулдаг сургалт бол хүүхдийг хөтөчтэй эсвэл бие даан нэг газраас нөгөөд саадгүй зорчиход дэмжлэг үзүүлэх зорилготой байдаг. Хэрэв эрхэм багш таны ажиллаж амьдардаг газар нутагт орон зайн чиг баримжаа олгох, хөдөлгөөний ур чадвар сайжруулах сургалт зохион байгуулах чадвартай мэргэжилтэн байвал ийм сургалтыг нутаг орондоо зохион байгуулах боломжтой гэсэн үг. Энэ боломжийг багш Та аль болох үр дүнтэй ашиглахыг хичээгээрэй.

Жишээлбэл, харааны бэрхшээлтэй хүүхэдтэй харилцахдаа тэр, энэ, тэнд, наана, цаана гэх мэт тодорхойгүй үгсийг хэрэглэх нь зохимжгүй байдаг. Өөрийг нь дуудахдаа нэрээр нь дуудаад, өөрт нь хандаж ярих ёстой. Ярилцахдаа тодорхой, бодитой, ойлгомжтой ярилцах шаардлагатай байдаг. Тодруулбал, баруун гар талын чинь урд талд тийм зүйл байна. Яг эгц урд ширээ байна, ширээн дээр тийм зүйл байна гэх мэтээр ойлгомжтой тайлбарлах хэрэгтэй. Тухайн хүүхэд ямар нэгэн зүйл харах шаардлагагүйгээр багшийн ярианаас ойлголт авч чадахуйц байхаар үг, хэллэг сонгож ярилцах шаардлагатай болно. Зүг чиг, орон зайг тодорхойлж ярихдаа зүүн гар талд хоёр алхмын зайд тийм дүрстэй, тийм зүйл байна гэх мэтээр тодорхой ярих хэрэгтэй.

2.3 Харааны бэрхшээлтэй хүүхдүүд суралцах ба сурснаа илэрхийлэх арга замууд

Суралцагчид мэдээллийг харилцан адилгүй байдлаар хүлээн авч, ойлгодог учир мэдлэг эзэмших аль болох олон арга замыг тэдэнд эзэмшүүлэхийн төлөө ажилладаг билээ. Багш нарынхаа ийм хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх зорилгоор гарын авлагын энэ хэсэгт зарим боломжит арга замыг зөвлөмж болгож байна.



А. Олон мэдрэхүйг зэрэг ашиглах замаар суралцах

Бүх суралцагчийг мэдээлэл хүлээн авах тэгш боломжоор хангахын тулд мэдээллийг харааны бус хувилбараар хүргэх нь чухал. Багш хараагүй болон сул хараатай сурагчдын сонсгол, хүрэлцэхүй, амтлах, үнэрлэх мэдрэхүйг ашиглах замаар мэдээлэл хүлээн авах хэрэгцээг хангах боломж бололцоог идэвхтэй эрэлхийлэх хэрэгтэй. Энэ хэлбэрийн суралцахуйн үйл явц нь сурагчдыг нэгээс илүү мэдрэхүйн эрхтнээр дамжуулан суралцахыг дэмждэг тул олон мэдрэхүйг зэрэг ашиглах замаар суралцах гэж ерөнхийлөн нэрлэдэг байна.

Жишээ нь:

- Бүх зураг, график, видео, хөдөлгөөнт дүрс дээр тайлбар бичих (текст эсвэл яриа)
- Агуулгыг дүрслэхдээ брайл график болон гол дүрслэлийг илэрхийлэх объект ашиглах
- Харилцан үйлчлэл эсвэл дүрслэлийг тайлбарлахдаа биет үзүүлэн, орон зайн баримжаа олгох загварыг ашиглах
- Харж ойлгох мэдээллийн гол санаа, шилжилтийг тайлбарлахдаа дуу чимээ ашиглах
- Аливаа зүйлийн гол шинж чанарыг маш тодорхой ярьж тайлбарлаж өгөх (жишээ нь, тэмээ хоёр бөхтэй, урт хүзүүтэй, гонзгой толгойтой г.м)

Б. Өдөр тутамд хэрэгтэй амьдрах ур чадварыг хүүхдэд заах талаар эцэг эхтэй нь зөвшилцөх

Харааны бэрхшээлтэй хүүхэд сургуульд элсэн суралцахдаа хувцсаа өмсөх, тайлах, хоол идэх, ариун цэврийн өрөө хэрэглэх зэргээр өдөр тутмын амьдралд зайлшгүй хэрэг болдог зарим чадваруудыг эзэмшээгүй байж болно. Иймд багш тухайн хүүхдийн эцэг эхтэй нь ярилцаж, эдгээр чадваруудыг хүүхдэдээ эзэмшүүлэх хамгийн тохиромжтой хүмүүс нь эцэг эхчүүд өөрсдөө гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Үүний тулд эцэг эхчүүд:



- Хүүхдэдээ юу хийх ёстойг нь тайлбарлаж өгөх



- Хэрвээ тодорхой хэмжээнд харах чадвартай хүүхэд бол юу хийх ёстойг нь үзүүлэх



- Хүүхэд уг үйлдлийг бие даан гүйцэтгэхэд нь тусалж, дэмжих

2.4 Харааны бэрхшээлтэй хүүхдүүд үйлдэл хийх, илэрхийлэх арга замууд

Хүүхэд бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг тул багш сурагчдаа өөрсдийгөө илэрхийлэх олон арга замыг эзэмшихэд нь бүх талаар туслах хэрэгтэй.

А. Туслах хэрэгслээр хангаж, хэрхэн ашиглахыг зааж өгөх

Харааны бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулж байгаа гол зорилго нь тэднийг ирээдүйн амьдралд бэлтгэж буй явдал билээ. Иймд тухайн хүүхэд ирээдүйд гэртээ ч, ажил дээрээ ч хэрэглэх технологид эртнээс суралцаж, бэлтгэлтэй байх нь чухал юм. Мөн суралцахуйн үйл явцаар дамжуулж сурагчдад өөрсдийгөө илэрхийлэх олон арга зам зааж өгөх нь тэдний одоогийн болон ирээдүйн гүйцэтгэлийг үнэлэхэд чухал ач холбогдолтой. Иймд сургалтын агуулга нь хүүхдийн чадамж болоод аливаа дасгал даалгаврыг гүйцэтгэхэд аль хэрэгсэл нь илүү тохиромжтой болохыг сурагчдад заахад чиглэх ёстой.

Б. Хүүхдийн мэдлэг ойлголтыг үнэлэхэд тохирсон үнэлгээний аргачлалтай байх

Сурагчдыг үнэлэхдээ хүүхэд бүр сурсан мэдлэг, ойлгосноо илэрхийлэх, харуулж чадах байдлаар үнэлэх нь зүйтэй. Харааны бэрхшээлтэй хүүхдэд үзэг харандаа бариулаад бичгээр шалгалт авбал тухайн хүүхэд сурсан мэдсэнээ хангалттай хэмжээнд илэрхийлж чадахгүй байж мэднэ. Хэрэв багш тухайн хүүхдийн бичгийн чадварыг үнэлэхийг зориогүй бол өөр ямар нэг аргаар өөрийгөө илэрхийлэх боломж олгох ёстой. Тиймээс хүүхдийн онцлогт тохирсон хэлбэрээр дасгал даалгавар өгөх, хугацааг нь сунгах зэрэг тохируулга хийх нь тухайн хүүхдэд төдийгүй багш, ангийн бусад хүүхдүүдэд ч тохирсон арга байж болно.

Ахицаар үнэлнэ гэдэг нь өдөр бүр хүүхдийн гүйцэтгэлийг ажиглаж, тогтмол санал зөвлөмж өгч байхыг хэлдэг. Багш хэзээ хүүхдийн ахицыг тэмдэглэх эсвэл хүүхдэд дэмжлэг туслалцаа үзүүлэхээ шийдэхдээ дараах зүйлсийг анхаараарай:

1. **Ажиглах.** Хүүхэд дасгал даалгавраа хэрхэн гүйцэтгэж байгааг анхааралтай ажиглаарай. Зөвхөн шаардлагатай тохиолдолд тусламж, чиглүүлэг өгөх нь үр дүнтэй.
2. **Оролцох.** Даалгаврын зарим хэсгийг хийж дуусгахын тулд Та хүүхдэд өөрөө тусалж, үйл ажиллагаанд нь оролцож болно.
3. **Үнэлэх.** Өгөгдсөн даалгаврыг бусдын тусламжгүйгээр төвөггүй хийж байна уу эсвэл хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна уу гэдгийг зохистой аргаар үнэлээрэй.
4. **Дахин шалгаж үзэх.** Хэрэв сурагч өгөгдсөн даалгаврыг амжилттай хийсэн бол хүүхдийг урамшуулж, дараа нь дахин шалгаж урам нэмэх хэрэгтэй.
5. **Дахин бодолцож үзэх.** Хэрвээ хүүхэд даалгавраа гүйцэтгэж чадаагүй бол түүнийг тайвшруулж, дараагийн алхмаа төлөвлөөрэй. Жишээ нь даалгаврын заавар зөвлөмжийг тодорхой өгөх, даалгаврыг хялбаршуулах, хүүхдэд илүү дэмжлэг үзүүлэх, өөр боломжит даалгавар сонгох гэх мэтээр аль болох урамыг нь хугалахгүйгээр ажиллаарай.
6. **Тэмдэглэх.** Хүүхдийн гүйцэтгэлийг тогтмол тэмдэглээрэй. (бичвэр, зураг, тухайн долоо хоногт бичсэн тэмдэглэл хэлбэрээр байж болно) Ингэвэл дараагийн шатанд тухайн хүүхэдтэй ажиллахад илүү өгөөжтэй байх болно.



3

БҮЛЭГ

**ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ
БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИЙГ
ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ НЬ**

3.1. Хэл яриа, харилцааны бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт

Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхэд бусдын гаргаж буй дуу авиаг ойлгох, авиаг зөв дуудах, үгээ зөв сонгож, хооронд нь нийлүүлэн утга төгс өгүүлбэр бүтээхдээ ихээхэн хүндрэлтэй тулгардаг. Зарим хүүхэд ээрүү, бас зарим нь авианы гажиг дуудлагатай байх жишээтэй. Аутизмын хүрээний эмгэгтэй буюу харилцааны бэрхшээлтэй хүүхэд бусадтай харилцах, хүний нүд рүү эгцлэн харах зэрэг нийгмийн энгийн харилцааг төдийлөн сайн ойлгодоггүй учраас ангийн дүрэм журмыг дагаж мөрдөхгүй байх хандлага түгээмэл тохиолдоно.

Хэл ярианы бэрхшээл нь хүүхдийн нийгмийн харилцааны ур чадварт сөргөөр нөлөөлдөг. Бусадтай хэрхэн харилцахаа мэдэхгүй байхаас гадна эргэн тойрны хүмүүсийн гаргаж буй дуу авианууд хүүхдийг тав тухгүй байдалд оруулж, түгшүүрт автуулдаг учир тухайн хүүхэд аль болох хүнтэй харилцахаас зайлсхийж, улмаар бүрэг ичимхий болдог талтай. Тэр хэрээр өөртөө итгэх итгэл нь буурна. Тиймээс зарим хүүхдүүд гэр бүлийн харилцаанд боломжийн хэмжээнд оролцдог ч сургууль дээрээ хэнтэй ч ярихгүй байх тохиолдол бий. Энэ бол хүүхэд хангалттай хэмжээнд өөрийгөө илэрхийлэх чадвар сул байна гэсэн үг. Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэд өөрийгөө илэрхийлж чадахгүй байгаа үедээ зан ааш нь тогтворгүй болж, уцаартай болох явдал их гардаг. Энэ бол уг хүүхэд ерөөсөө бусадтай харьцах чадваргүй гэсэн хэрэг биш юм.

Ийм хүүхдүүдэд бусадтай ямар нэгэн байдлаар харилцах зохих хэмжээний чадвар байдаг бөгөөд гагцхүү тухайн хүүхэд хүнтэй хэрхэн харилцдаг, түүнийг нь хэрхэн хөгжүүлж болох вэ гэдэг талаар багш судалж мэдэхийг хичээхийн зэрэгцээ сургуулийн хамт олон нь ч санаа тавих хэрэгтэй. Багш хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн талаар нэлээд тодорхой судалгаа хийсний үндсэн дээр тэдгээр хүүхэдтэй үгээр биш ч гэсэн өөр янз бүрийн хувилбараар харилцах, ойлголцох арга замыг олох боломж бүрддэг байна.

3.2 Хэл яриа болон харилцааны бэрхшээлтэй хүүхдүүдийг сэдэлжүүлэх замаар оролцоог хангах арга замууд

Суралцагчдын сурах сэдэл харилцан адилгүй учир багш Та хүүхдийг суралцах үйл явцад идэвхтэй оролцуулах аль болох олон арга замыг олж ашиглах талаар бүтээлч эрэл хайгуул хийх нь зүйтэй. Бид таны эрэл хайгуулд туслах зорилгоор зарим нэг арга замыг жишээ болгон танилцуулж байна.



• Хүүхдийн сонирхол, чадвар чадамжид тулгуурлан багшлах

Бусад хүүхдүүдийн адил хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхэд ч юуг, хэрхэн сонирхох нь хүүхдийн онцлогоос шалтгаалж харилцан адилгүй байна. Зарим сурагчид шинэ, шинэлэг санаачилгад дуртай байдаг бол бусад нь тогтсон хэв загвараар суралцахыг илүүд үздэг. Жишээ нь ихэнх аутизмтай хүүхдүүд тодорхой тогтсон дадлын дагуу хичээллэх нь үр дүнтэй бөгөөд энэ нь тухайн хүүхдийг тайван, тогтвортой байхад тусалдаг. Үүнтэй адил зарим сурагч ганцаараа хичээллэхийг илүүд үздэг бол бусад нь багийн ажилд идэвх, санаачилгатай оролцдог байх жишээтэй. Мэдээж бүх суралцагчийн нөхцөл байдалд тохирсон тэдний оролцоог хангах тогтсон оновчтой загвар гэж үгүй (CAST, 2018). Гэхдээ багш хүн аль болох бүх хүүхдэд хүртээмжтэй байх арга замыг олохын төлөө тогтмол идэвхтэй ажиллах хэрэгтэй. Наад зах нь хүүхдүүд таныг эрэл хайгуул хийж байгааг мэдэрч танд туслахын төлөө өөрсдөө идэвх гаргах болно.

Энэ ажлын хүрээнд багш хүүхдийнхээ хэрэгцээ сонирхлыг танин мэдэх зорилгоор өөртэй нь болоод эцэг эхтэй, ах дүү, найз нөхөд зэрэг идэвхтэй харилцдаг хүмүүстэй нь ярилцаж харилцан ойлголцвол хамгийн үр дүнтэй арга болдог. Тухайлбал, ийм уулзалт ярианы үр дүнд аутизмтай хүүхдүүд ихэнхдээ тодорхой нэг сэдэв эсвэл эд зүйлд (эргэдэг тоглоом, тодорхой нэг бүтэц найрлага, комикс дүр г.м) онцгой их анхаарч, ач холбогдол өгдөг болохыг мэдэж авлаа гэхэд багш тухайн хүүхдийн энэхүү сонирхлоор нь дамжуулж, өдрийн тодорхой цагуудад хүүхдийн оролцоог хангасан хэлбэрээр хичээлээ зааж болно.

Хүүхдүүд илүүтэй сэтгэлийг нь хөдөлгөсөн хичээлд идэвхтэй оролцож, сэтгэгдлээ хуваалцаж, асуулт асуух нь элбэг. Иймд хүүхдийн эерэг сэтгэл хөдлөлийг бий болгож байгаа дуртай номыг нь дахин унших боломж олгож, тодорхой сонирхсон асуултад хариулах, багш өөрөө асуулт тавих зэргээр идэвхтэй харилцаж чадвал сургалтын явцад хандах хүүхдүүдийн санаачилга, оролцоо илүү сайжирна гэдгийг анхаараарай.

Хүүхдүүд уншиж сурахаасаа өмнө үлгэр, түүх олон дахин сонсож, хэл ярианд өөрийгөө дасгах сонирхол өндөр байдаг. Энэ онцлогийг харгалзаж тэдний сонирхлыг татаж буй үлгэр, түүхийг энгийн бөгөөд хөгжилтэй байдлаар ярьж, тэдэнд асуулт тавин хариулт авах зэргээр сонирхлоор нь дамжуулж идэвхжүүлэх арга замыг өргөн ашиглавал үр дүнтэй байж болно.

Хүүхэд өөрөө хийхийг хүссэн нөхцөлд, эсвэл багш өөрөө төлөвлөсний дагуу бүлгийн ажлын хүрээнд хүүхдүүдтэй хамт дуу дуулж, шүлэг уншиж хамтдаа хөгжилдөхийг хичээгээрэй. Ингэснээр хүүхдүүд Танд итгэж, ойр дотно харилцах сэдэл төрж эхэлнэ. Чухам энэ үед нь эд зүйл, хүүхэлдэй гэх мэт биет үзүүлэн ашиглан ярьж буй түүх, уншиж буй шүлэг, дуулж буй дуугаа илүү бодитой, сонирхолтой болгох боломжууд бий болно. Энэ мэтээр хүүхдийн суралцах үйл явцыг багш хүүхдүүдтэйгээ хамт бодит үйлдлээрээ дэмжээд байвал хичээл сонирхолтой, хүүхдийн оролцоо ч өндөр байх болно гэдгийг ямагт бодолцож ажиллаарай.

3.3 Харилцааны бэрхшээлтэй хүүхдүүд сурсан мэдсэнээ үзүүлэх арга замууд

Харилцааны бэрхшээлтэй суралцагчид бэрхшээлийнхээ төрөл, хэмжээ, өсөж торнисон орчин нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс хамаарч аливаа мэдлэг, мэдээллийг харилцан адилгүй байдлаар хүлээж авч, ойлгодог учир багш сурагчдыг мэдлэг эзэмших, мэдээлэл хүлээж авах, түүнийгээ илэрхийлж үзүүлэх аль болох олон хувилбар бүхий арга замыг сургалтын явцад ашиглахыг хичээж ажиллах хэрэгтэй болдог. Бид энд зарим нэг арга замын тухай товч мэдээлэл өгч байна. Үүнийг багш Та өөрийнхөө мэдлэг туршлагаар баяжуулж ажиллаарай.

• Хүүхэд хэрхэн бусадтай харилцаж буйг анхаарах

Харилцааны бэрхшээлтэй хүүхдүүд үг хэлээр ярихгүй ч хичээлийн явцад юу сурч мэдсэн, сурсан мэдсэнийгээ өөрийнхөөрөө илэрхийлэх олон арга замыг ашиглаж байдаг учраас багш тэр бүрийг сайн ажиглаж, сургалтынхаа явцад анхаарч байх нь чухал. Тухайлбал, харилцааны бэрхшээлтэй хүүхдүүд дараах үйлдлүүдээр өөрийгөө илэрхийлэх нь нэлээд түгээмэл байдаг. Үүнд:

- Биеийн хэлэмж
- Эд зүйл болон хүмүүстэй огт харилцахгүй байх
- Том хүн хүүхдээс асуулт асуухад нүд рүү нь хараад удалгүй болих
- Тэмдэглэгээ эсвэл зураг руу заах (нүд, гар, хөлөөрөө заах)
- Дохио эсвэл дохио зангаа
- Бичих эсвэл зурах

Одоо харилцааны бэрхшээлтэй хүүхдүүдийн өөрийгөө илэрхийлэх дээр дурдсан хэлэмжүүдийг багшлах арга зүйдээ ашиглах зарим зөвлөмжийн тухай товч танилцуулъя.



- **Хүүхдэд зураг ашиглах, солилцох байдлаар харилцах аргыг зааж өгөх**

Үг хэлээр өөрийгөө илэрхийлж чадахгүй байгаа хүүхэд зураг ашиглахыг хамгийн оновчтой арга гэж сонгох нь их түгээмэл байдаг. Багш хүүхдийн авахыг хүссэн эд юмс эсвэл хийхийг хүссэн зүйлийг зургаар илэрхийлэх аргыг сонгосноор хүүхдийн юу хүсэж байгааг ойлгоход тус болно. Хүүхэд нэг зурагтай харьцаж эхлэх ба аажмаар хэрэглэдэг зургуудаа нэмэх байдлаар багштай харилцаж, улмаар сургалтын үйл явцад оролцох идэвх нь сайжирдаг байна.

- **Хүүхдийн суурь чадвар дээр үндэслэж, хичээлээ заах**

Хүүхдүүдийн суралцахуйн үйл явцыг бүхэлд нь дэмжиж, хөгжлийн дараагийн ахиц дэвшилд хүрэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх гол хүн нь багш Та мөн. Багш бол хүүхэд бүрийн суурь чадвар дээр үндэслэж, суралцахуйн үйл явцыг тухайн хөтөлбөрийн хүрээнд залж чиглүүлэх хариуцлагатай бөгөөд хүндтэй үүргийг хүлээдэг. Энд

багшийн энэ олон талт үйл ажиллагааны жишээ болгон зарим санааг зөвлөмж болгож байна:

- Багш хүүхдийн хэлсэн үгийг давтахдаа үг нэмэх нь тухайн хүүхдийг дараагийн шатанд хүрэхэд дэмжлэг үзүүлж буй нэг хэлбэр юм. Жишээгээр тайлбарлавал хүүхэд шил рүү заагаад “сү” гэвэл багш түүнийг буцааж хэлэхдээ “сүү” болгож өөрчлөх, хүүхэд “автобус” гэвэл багш “улаан автобус”, хүүхэд “аав явчихлаа” гэвэл багш “аав дэлгүүр рүү явчихлаа”, хүүхэд “тоглоом ус уумаар байна” гэвэл “хүүхэдэй чинь цангасан юм уу, ус уумаар байна уу?” гэх мэтээр тухайн нөхцөлд байдалд нь тохируулж хүүхдийн хэл ярианы чадварыг хөгжүүлж болно.
- Хэрэв хүүхэд ямар нэг зүйлийг буруу хэлбэл багш заавал алдааг нь тодотгох шаардлагагүй. Тухайн хүүхдийг юун дээр алдаж буйг ажиглаад зөв хувилбарыг хариултаараа өгөхөд болно. Жишээ нь хүүхэд нохой руу заангаа “энэ бол нохой” гэвэл багш “тийм ээ чиний зөв, энэ бол нохой” гэж хариулах хэрэгтэй.

• **Нүдээрээ заах**

Энэ аргыг хүүхдээс зөвхөн “тийм”, “үгүй” гэсэн хоёр хариулттай хаалттай асуулт асууж байгаа тохиолдолд хэрэглэх бөгөөд өөр орлуулах хувилбар байхгүй үед тохирсон арга юм. Эхлээд хоёр алгаа толгойныхоо хажуу талд байрлуулна. Аль тал нь “тийм”, аль нь “үгүй” гэдгийг хүүхдэд сайтар ойлгуулах хэрэгтэй. Хүүхдээс асуултаа асууж, хариултаа авна (тийм бол баруун гар руугаа заах, үгүй бол зүүн гар руугаа заах). Дараа нь хүүхэд гар руугаа харахад та асуултаа давтаж асууна. (чи тийм гэж хариулсан болохоор би чамайг шүүс уумаар байна гэж ойлголоо г.м)

• **Ярьдаггүй хүүхдийн нийгмийн харилцааг дэмжих, урамшуулах, хамт тоглох**

Ярьдаггүй хүүхдийн харилцааг дэмжих олон арга байж болох ч хамт тоглох арга хамгийн үр дүнтэй гэж мэргэжилтнүүд үздэг байна. Хэрэв бусадтай тоглох дургүй хүүхэд байвал багш тухайн хүүхдийг тоглоомд оролцуулахын тулд удирдан чиглүүлэх хэрэгтэй. Ингэхдээ чимээгүйхэн явж хүүхдийн хажууд очоод үйлдлийг нь дуурайх, хэрэв тоглож байвал тоглоомд нь оролцох зэргээр хамт тоглож эхэлнэ. Хүүхэд юунд төвлөрч, юуг сонирхон харж буйг сайтар ажиглах бөгөөд тухайн хүүхдийг эхэлж харилцан яриа эхлүүлэх хүртэл тэвчээртэйгээр хүлээгээрэй.

• **Хүүхдийн хийж буй үйлдэлд багш тайлбар хэлэх**

Хүүхдээс шууд асуулт асуухаас өмнө хийж буй үйлдлийнх нь талаар санал сэтгэгдлээ хэлж анхаарлыг хандуулбал хүүхдүүд хариу үйлдэл үзүүлэх, асуултад хариулах магадлал өндөр байдаг. Бага ч гэсэн хэмжээгээр хүүхдийг шалгасан буюу “Энэ ямар

өнгө вэ?” эсвэл товчхон “тийм”, “үгүй” гэж хариулагдах асуултууд тавих нь харилцан ярианы өрнөлтийг эвдэж, яриа тасалдахад хүргэж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Түүний оронд “Чи үнэхээр өндөр цамхаг босгожээ” гэх мэтээр хүүхдийн хийж буй үйлдэл дээр нь сэтгэгдлээ хэлэх замаар харилцвал илүү үр дүнтэй. Энэхүү сэтгэгдэл хэлэх арга нь хийж буй зүйлээс нь хүүхдийн анхаарлыг сарниулахгүй байхаас гадна хүүхдийн ярианы хөгжлийг дэмжиж өгдөг давуу талтай.

• **Ээрүү хүүхдийн оролцоог дэмжих хамгийн боломжит хувилбарыг ашиглах**

Ээрүү хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжих хэд хэдэн арга бий. Ийм хүүхэд бол ярьж чаддаггүй биш, харин ярих явцдаа тасалдах, үг хэлж чадахгүй хэсэг хугацаанд саатах зэрэг онцлогтой байдаг учраас яриаг дэмжих хамгийн оновчтой аргыг олох нь чухал. Бид энд сонголт хийх боломжтой зарим аргыг зөвлөмж болгож байна. Үүнд:

Хүүхдийн өмнөөс үгийг нь гүйцээх гэж яарах хэрэггүй, ярих гэж оролдож буй хүүхдэд аль болох үгээ гүйцээх хугацаа олгоорой. Хүүхдийг ээрсэн үед нь өмнөөс үгийг нь гүйцээх хялбар санагдаж болох ч хүүхдэд үгээ гүйцээж хэлэх цаг өгч, яаруулахгүй байх нь хамгийн үр дүнтэй арга юм. Багшийн зүгээс бусад хүүхдүүд мөн ярианыхаа хэмнэлийг удаашруулах, цэгцтэй ойлгомжтой ярихыг зөвлөх, түр хүлээгээрэй гэх зэргээр тухайн хүүхдэд яарах шаардлагагүй гэдэг дохиог өгөх хэрэгтэй.

Хүүхдэд яриагаа удаашруулаарай, хурдлаарай эсвэл гүнзгий амьсгаа аваарай гэх мэтээр ямар нэг байдлаар сандралд оруулах үг хэлэх, үйлдэл үзүүлэхээс болгоомжлоорой. Ээрдэг хүн өөрийнхөө хэл ярианд учирдаг бэрхшээлүүдийг анзаардаг ч үүнийгээ засаж чаддаггүй тул бусад хүмүүсийн шууд өгсөн зөвлөгөөг төдийлөн сайшаадаггүй гэдгийг анхаарч тийм хүүхдэд хэл яриагаа сайжруулах талаар зөвлөгөө өгөх бол энэ онцлогийг харгалзсан оновчтой аргыг сонгоорой.

Самбарын өмнө гарах, чанга унших зэрэг стресс ихтэй нөхцөл байдалд хэрхэн өөрийгөө удирдах талаар ярилцаж дор дурдсан зүйлүүдэд онцгой анхаарч байх нь чухал. Үүнд:

- Ямар ч хүүхэд бэлтгэлтэй, тайван үедээ стресстэй нөхцөл байдалд өөрийгөө удирдаж чаддаг. Суралцагч бусдын өмнө чангаар ярих дасгалыг хийж байх хэрэгтэй байдаг ч багш үүнд хэт ач холбогдол өгч, хүүхдийг бэлтгэж эхлэх нь эргээд хүүхдэд цочроо өгч, түгшүүрт автуулдгийг анхаарах хэрэгтэй. Багш стресстэй орчинд өөрийгөө илэрхийлэх талаар хүүхэдтэй ажиллаж байгаа нөхцөлд юуны өмнө тухайн хүүхэдтэй сайн ярилцаж, ойлголцохыг чухалчлаарай.
- Хүүхдийг нэрсийн дарааллаар эсвэл ширээ ширээгээр нь дуудаж, чанга унших дасгал хийлгэх нь ээрүү хүүхдийн хувьд илүү хүндрэлтэй байдаг. Учир нь хүүхэд

ээлжээ хүлээх зуураа тогтворгүй болж, түгшүүрт автаж эхэлдэг байна. Иймд багш тухайн хүүхдийн нэрийг хамгийн эхэнд дуудах болон тохиолдлоор дуудах аргуудыг хэрэглэж болно. Хүүхэдтэйгээ ярилцсаны үндсэн дээр аль нь илүү тохиромжтой болохыг шийдэж байгаарай.

- Хэрэв ангийн сурагчдаас нь дээрэлхсэн, тохуурхсан өнгө аяс мэдрэгдвэл багш асуудлыг нэн даруй зохицуулж шийдэх хэрэгтэй. Удах тусам хүүхдийн ээрүү хүндэрч болохыг анхаараарай.
- Сонсох, ээлжээ хүлээх, бусадтай найрсаг харилцах, цэвэрлэгээнд туслах, урлаг спортын авьяас зэрэг сайн чаддаг зүйлийг нь урамшуулан магтвал үр дүн өгдөг.

• **Үнэлгээний аргачлалыг хүүхдийн ур чадварт нийцүүлж тохируулах**

Багш хүүхдийн ахиц, дэвшлийг тогтмол ажиглаж, тэмдэглэж байхаас гадна, үнэлгээний аргачлалыг тухайн хүүхдэд хүртээмжтэй байдлаар тохируулж байх нь чухал.

Хүүхэд сурсан мэдлэг ойлголтоо илэрхийлэхэд дараах 4 хүчин зүйл саад болж байдаг бөгөөд багш эдгээрийг дор бүрд нь анхаарч хүүхдийн ур чадварт нийцүүлсэн тохируулга хийхийг хичээгээрэй.



1. Арга барил

Багш нар хүүхдэд хандаж заавар, мэдээ мэдээллийг хүргэх арга барилаа нөхцөл байдалд нь тохируулан өөрийн сонголтоор өөрчилж байдаг. Энэ бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд унших, сонсох зэргээр харааны болон сонсголын мэдрэхүйгээр мэдээлэл хүлээн авахаас илүүтэй, мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр эзэмших өөр бусад аргуудыг ашиглах боломж бүрдэнэ гэсэн үг юм. Харилцааны бэрхшээлтэй хүүхдийн хувьд чухал мэдээллийг тодруулах, дасгал даалгаврыг харахад ойлгомжтой болгох, багш энгийн зааварчилгаа өгөх зэргээр тохируулга хийж болно.

2. Хариу үйлдэл

Сурагч сурсан мэдлэгээ зөвхөн аман яриагаар илэрхийлж танилцуулах хэлбэрийг аль болох бага ашиглах хэрэгтэй. Түүний оронд өөр бусад үнэлгээний аргачлалыг туршиж болно. Жишээ нь компьютер дээр шивэх, гол санааг дугуйлах эсвэл заах, математикийн хичээлийн хариуг тооны машин дээр үзүүлэх эсвэл 1-100 хүртэлх тооны үзүүлэн дээр зааж болно. Мөн санаагаа зураглах буюу цэгцтэй бодож сэтгэх дасгалаар дамжуулж хүүхэд оюун бодлоо цэгцлэх боломжтой байдгийг ч тооцоорой.

3. Зохион байгуулалт


Багш хүүхдийн мэдлэг чадварыг хамгийн боломжит байдлаар үнэлэхэд ямар зохион байгуулалтууд шаардагдах вэ гэдгийг сайтар бодолцох хэрэгтэй. Жишээ нь, аутизмтай хүүхдүүд хэт их чимээ, тод гэрэл, хурц үнэрт анхаарал нь сарнидаг тул гал тогоотой ойр биш чимээгүй орчинд шалгалтаа өгөх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй юм.

4. Хугацаа

Энэ бол сурагчдад шалгалт, даалгавраа дуусгах нэмэлт хугацаа өгөх, их даалгаврыг жижиг хэсгүүдэд хуваах, ойлгохгүй тохиолдолд заавар чиглүүлэг өгөх, өдрийн тодорхой цагт шалгалт авах зэрэг цаг хугацаатай холбоотой тохируулгууд юм. Багш энэ тохируулгыг оновчтой хийж чадвал ажлын үр дүнд шууд нөлөөлдөг байна.

3.4 Харилцааны бэрхшээлтэй хүүхдүүд үйлдэл хийх, илэрхийлэх арга замууд

Харилцааны бэрхшээлтэй хүүхэд бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг учраас багшийн зүгээс сурагч болгонд өөрсдийгөө илэрхийлэх олон арга зам байж болохыг ойлгуулж, мэдрүүлэх суралцахуйн үйл явцыг удирдах шаардлагатай.



• **Хүүхдийн үгийн санг баяжуулах**

Суралцагчид аливаа сэдвийг заахдаа тухайн сэдэвтэй холбоотой хүүхдийн өмнөх мэдлэг, ойлголтыг сэргээж, түүнд тулгуурлан суралцахуйн үйл явцыг зохион байгуулах нь үр дүнгээ өгдөг гэдгийг багш та бүхний олон жилийн туршлага нотолдог билээ. Зарим сурагч багшийн заах гэж буй сэдвийн талаар ямар ч ойлголтгүй байж болно, ойлголттой ч шинээр заах үед сэдэвтэй хэрхэн уялдахыг мэдэхгүй байж болно. Тиймээс өмнөх мэдлэгийг сэргээж, танин мэдэхүйн чадваруудыг идэвхжүүлэх, эсвэл шинээр зааж буй сэдэв нь өмнөх мэдлэгтэй нь хэрхэн холбогдохыг тайлбарлаж өгөх зэргээр хүүхдийн суралцахуйг олон янзаар дэмжихийг эрхэмлээрэй. Үүнд холбогдох зарим нэг нэмэлт аргуудыг дурдвал:

Хүүхдийн өмнөх мэдлэгийг сэргээхийн тулд утгын зураглал хийх шаардлага гарч болох юм. Ийм тохиолдолд сурагчдыг баг болгон хувааж хичээлийн сэдвийн талаар: а) юу мэдэх, б) юуг мэдмээр байна, в) хичээлийн төгсгөлд юу сурснаа эргэж дүгнэж, ярилцах гэсэн даалгавар өгөөрэй. Сурагч сэдвийн талаар юу мэдэж буйгаа заавал хэл яриагаа илэрхийлэх шаардлагагүй бөгөөд цаасыг гурван багана болгон нугалаад дээр нь зурах эсвэл утгын зураглал хийж болох юм. Мөн бичих чадварт сайн суралцагчаар бүлгээ удирдуулж, санаагаа ярилцан бичүүлэх боломж бий.

• **Сурагчдад ойлгуулах ёстой гол санаагаа урьдчилан бэлд**

Багш зааж буй сэдэв болон агуулгаас зайлшгүй мэдэх ёстой гол санааг сурагчдад хүргэх олон төрлийн арга замыг өөрсдөө тодорхойлж ажиллах шаардлагатай болдог (жишээ нь аудио ном, диаграмм үзүүлэн, YouTube-ийн бичлэг, харьцуулалт эсвэл зүйрлэл). Ийнхүү тодорхойлсон арга барил, хичээлийнхээ агуулгын талаар хүүхдийн эцэг эхтэй хуваалцвал тухайн хүүхэд гэртээ мөн суралцах боломж бүрдэх сайн талтайг анхаараарай.



4

БҮЛЭГ

**СОНГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ
СУРАЛЦАГЧИЙГ ТЭГШ
ХАМРУУЛАН СУРГАХ НЬ**

4.1 Сонголын алдагдлын талаарх ерөнхий ойлголт


Сонголын алдагдлыг хэмжих тестийн үр дүнгээр хүүхэд нэг чихээрээ (нэг талын) эсвэл хоёр чихээрээ (хоёр талын) тодорхой түвшний дуу чимээ сонсож чадахгүй байхыг сонголын алдагдал гэж нэрлэдэг. Хамгийн бага хэмжүүр нь 15-20 децибел (дб) буюу дуу чимээний мэдрэгдэх хүч бөгөөд навч сэрчигнэх, хүмүүс шивнэлдэх чимээ юм. Хэрэв хүүхдийн сонголын алдагдал 25-40 дб хооронд байвал бага зэргийн алдагдалтай, 41-60 дб байвал дунд зэргийн алдагдалтай, 61-80 дб байвал хүндэвтэр алдагдалтай, 81-ээс дээш бол гүнзгий алдагдалтай гэж тооцох бөгөөд ямар ч төрлийн дуу чимээг сонсох боломжгүй бол бүрэн сонсголгүй гэж ангилна.

Түүнчлэн зарим хүүхэд эхээс төрөхдөө сонголын алдагдалтай буюу төрөлхийн шалтгаантай байдаг бол зарим хүүхдийн хувьд олдмол шалтгаантай байна. Түр зуурын сонголын алдагдал нь насан туршийн бэрхшээл биш хэдий ч тухайн хүний хэл ярианы хөгжилд сөргөөр нөлөөлдөг. Эдгээр хүүхдүүд нь багшийн заасан хичээлийн агуулгаас хоцрох, ангийн үйл ажиллагаа, хэлэлцүүлэгт оролцохдоо хүндрэлтэй тулгарах нь олонтоо. Хэрэв тухайн хүүхдүүд багшийн ярьсныг ойлгоогүй бол мэдлэг, ойлголт, үгийн сангийн хувьд бусдаасаа хоцрохоос гадна анхаарал төвлөрүүлэх гэж хэт их хичээснээс ядрах, сэтгэлээр унах, анхаарал төвлөрөлт нь буурах зэрэг үр дагавартай юм. Гагцхүү сургуулийн зүгээс хүүхдийг зөв дэмжиж тусалж чадвал сонголын алдагдалтай хүүхдүүд бусдын адил сурч боловсорч, хөгжих бүрэн боломжтой.



4.2 Сонголын бэрхшээлтэй хүүхдүүдийг сэдэлжүүлж оролцоог хангах арга замууд

Сонголын бэрхшээлтэй суралцагчдын сурах сэдэл харилцан адилгүй учир багш ийм төрлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлогийг харгалзан хүүхдийг суралцах үйл явцад идэвхтэй оролцуулах олон арга замыг сонгож ашиглах шаардлагатай.



Хүүхдийг сурах сэдлийг өдөөж, оролцоог хангах нь хүүхдийн хүсэл сонирхлыг татаж, сэтгэл хөдлөлөө зохицуулах боломж олгохоос гадна дасгал даалгаврыг хүчин чармайлт гарган гүйцэтгэх, суралцах үйл явцад идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Иймд багш сурагчийн сурах сэдэлд тохирсон оролцоог хангах олон арга замыг бодолцож багшлахуйн болон суралцахуйн үйл явцыг зохион байгуулж байдаг. Сонголын алдагдалтай сурагч багшийн хэлсэн мэдээллийг сонсохгүй өнгөрөөх, буруу сонсох эрсдэлтэй бөгөөд тэр хэрээрээ тухайн хүүхэд хичээлд оролцох идэвх сонирхол буурч байдаг. Тиймээс багш ангид болж буй үйл ажиллагаанд бүх хүүхэд идэвхтэй оролцдог сургалтын орчныг бүрдүүлэх арга замуудыг бүтээлчээр ашигласнаар суралцагчдын идэвх, оролцоог сайжруулах асуудлыг шийдэх боломжтой.

Сонголын бэрхшээлтэй хүүхдийг сэдэлжүүлж, суралцахуйн үйл явцад оролцох идэвхийг сэргээхэд ангийн зохион байгуулалт ба сургалтын орчин нэн чухал гэдгийг багш нар сайн мэднэ. Энэ чиглэлээр дараах асуудалд онцгойлон анхаарахыг зөвлөж байна.

Багшийн байрлал

Сургалтын явцад сурагч багшийг төвөггүй харж, сонсох боломжтой байх ёстой. Багш аль болох урд эгнээнээс хичээлээ заах бөгөөд ярьж байхдаа алхах, холхих зэрэг хөдөлгөөн хийхээс зайлсхийгээрэй. Мөн самбар дээр бичих үедээ ярихгүй байх, нүүрэн дээр нь сүүдэр тусахуйц цонхны дэргэд очиж зогсохгүй байхад анхаарах нь зүйтэй.

Сурагчийн суудлын хуваарь

Бэрхшээлтэй хүүхэд аль болох ангийн урд, үргэлж дэмжиж тусалдаг найзтайгаа хамт суух нь зөв. Мөн тухайн хүүхэд бусдын яриаг уруулын хөдөлгөөнөөр нь уншихын тулд бага зэрэг нэг тийшээ хазайсан байрлалтай сууж болно гэдгийг анхаарч байхад илүүдэхгүй.

У хэлбэрээр ширээ сандлаа байрлуулах

У хэлбэрээр ширээ сандлаа байрлуулбал бэрхшээлтэй хүүхэд хэн ярьж буйг харах боломжтой болно.

Ангид аль болох дуу чимээ гаргахгүй байх

Хүүхэд сонсголын аппарат зүүж байгаа тохиолдолд уг төхөөрөмж нь хүний яриа болон орчны дуу чимээг хамтад нь өсгөдөг. Тиймээс ангийн дуу шуугиан бэрхшээлтэй хүүхдэд илүү ачаалал өгч, төвөг учруулж мэднэ. Иймд багш чимээтэй орчинд хичээллэж байгаа бол хаалгаа хаах, хичээл заах үедээ ангийг аль болох нам гүм байлгах, сандлын хөл шал зурж байвал резинээр бэхлэх зэрэг арга хэмжээ авах шаардлагатай.

Хичээлийн явцад хүүхэд бүр ангийн хэлэлцүүлэгт оролцох, дасгал даалгавар хийх боломж, нөхцөлийг бүрдүүлж, хүүхэд бүрийн оролцоог дэмжих нь чухал. Ийм боломжийг бүрдүүлэхийн тулд юуны өмнө дараах чиглэлээр ажиллахыг санал болгож байна.

Санаагаа давтан хэлж, нэгтгэн дүгнэх

Хэрэв сонсголын алдагдалтай хүүхэд ангийн хойноос багшийн хэлсэн үгийг сонсоогүй бол багш санаагаа давтан хэлэх, ангийн урд байгаа сурагчдын санааг нэгтгэн дүгнэж, өөр үгээр илэрхийлэх зэрэг арга техник хэрэглэж болно.

Хүүхдэд ярьж буйгаа мэдэгдэж дохио өгөх

Багш ангийн бусад сурагчдыг бэрхшээлтэй хүүхэдтэй харилцахаас өмнө дохио өгөх, өөрийгөө танилцуулах, нэг нэгээрээ ярих зэрэг дадалд хэвшүүлээрэй.

Сайн найзын дэмжлэг

Хэрэв хүүхэд ямар нэг зүйл сонсохгүй орхигдуулбал давтан хэлж өгч, бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйн үйл явцад дэмжлэг үзүүлэх “сонсголтой найз”-тай байх хэрэгтэй. Бэрхшээлтэй хүүхэд заавал багшийн дэмжлэгийг хүлээлгүйгээр найзаасаа тусалцаа авч, дасгал даалгавраа хийж гүйцэтгэх боломжтой.

Дохио өгөх болон хүний нүд рүү эгцлэн харах

Хүүхэд бусдын яриаг эхнээс нь алдалгүй сонсохын тулд ярьж эхлэхээсээ өмнө бусдын нүд рүү эгцлэн харах, анхаарлыг өөртөө татах арга зүйг ашиглавал үр дүнтэй.

Суралцахуйн явцад суралцагчийн мэдлэг ойлголтыг нь шалгах шаардлага тодорхой хэмжээнд гардаг. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хувьд энэ ажлыг багш ихээхэн бэлтгэлтэй зөв зохион байгуулах учиртай. Сурагч таны заасан заавар зөвлөгөөг ойлгож, шинэ үг сурч буй эсэхийг нягтлахдаа нээлттэй асуулт асуух болон тухайн суралцагчтай хэлэлцүүлэг өрнүүлэх аргуудыг ашиглаарай. Хэрэв сурагч танаас нэмэлт тусламж хүсвэл тухайн хүүхэд хичээлд анхаараагүйдээ биш, сонсоогүй өнгөрөөсөн байх нь элбэг. Тиймээс сурагч санамсаргүй байдлаар таны асуусан асуултад хариулахгүй байж мэднэ. Мөн зарим тохиолдолд сурагч хэл яриагаар болон бичгээр аливааг илэрхийлэхдээ алдаа гаргаж болох бөгөөд энэ нь тухайн хүүхдийн сонсголын алдагдал, хөгжлийн хоцрогдолтой холбоотой учраас түүнийг нь харгалзан үзэх хэрэгтэй болдог билээ.

4.3. Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд сурсан мэдсэнээ олон хэлбэрээр үзүүлэх арга замууд

Сонсголын бэрхшээлтэй суралцагчид хөгжлийн бэрхшээлтэй бусад хүүхдээс онцлог байдлаар мэдлэг, мэдээллийг харилцан адилгүй хүлээж авч, ойлгодог учир багш сурагчдыг мэдлэг эзэмших болон сурч мэдсэнээ олон арга замаар илэрхийлэн үзүүлэх боломжоор хангах хэрэгтэй. Энд хэрэг болох зарим гол арга замыг бид зөвлөмж болгож байна.

Дүрслэлийн арга барилыг ашигла

Харааны мэдрэхүйд тулгуурласан дүрслэлийн аргыг ашиглах нь сонсголын бүрэн алдагдалтай хүүхдүүд сонсох, хэл яриа болоод уруулын хөдөлгөөн унших байдлаар мэдээлэл хүлээж авахаас гадна шинээр заасан сэдвийг агуулга, нөхцөл байдлыг ойлгоход дэм болдог. Дүрслэлийн арга барил нь шинэ санаа, үгийг зураглан ойлгоход дэмжлэг үзүүлэхээс гадна харааны санах ойн чадварыг дэмжиж, өмнө сурсан мэдлэгээ бататгахад тустай байдаг.

АРГА ЗҮЙ, ЗӨВЛӨМЖ**01****ХҮҮХДЭД МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ**

- Дохионы хэлээр харилцах
- Сонсгол, хэл яриа хөгжүүлэх

02**СУРГАЛТЫН ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН**

- Эерэг, зөв мэдээлэл түгээх
- Багшийг хөгжүүлэх боломж

03**СОЁЛ, ХАНДЛАГА ТӨЛӨВШҮҮЛЭХ**

- Нийгмийн харилцаа
- Сонсголгүйн соёл

04**ЭЦЭГ ЭХ, ОЛОН НИЙТИЙН АНХААРАХ ЗҮЙЛС**

- Зөв мэдээлэл – зөв ойлголт
- Хүүхдийг танин мэдэх, хөгжүүлэх
- Дохионы хэл эзэмшүүлэх

Энэ аргыг ашиглахдаа багш дараах зүйлийг анхаараарай.

- Үзүүлж буй дүрслэлээ тодорхой зааж өгөөрэй. Бусад сурагчид энэ тухай ангийн хэлэлцүүлгийн үед ярилцаж болно.
- Бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн дүрэм журмыг ойлгуулж, тогтоолгохын тулд цагийн хуваарийн үзүүлэн, утгын зураглалын аргыг ашиглаарай.
- Хүүхэдтэй дахин харьцаж эхлэхээс өмнө тухайн хүүхдэд дүрслэлийг харж ойлгох хангалттай цаг өгөөрэй. Энэ нь хүүхэд буцаад багшид анхаарлаа хандуулахад шаардлагатай хугацаа болж өгдөг. Хүүхдийн суралцахуйн төвшнөөс хамаарч багш дүрслэлийн аргыг ашиглаж болох олон жишээ байдгаас заримыг дурдья:

Сургуулийн өмнөх боловсролын бүлэг болон бага ангид:

Үлгэр түүх, дуу шүлэг, заавар зөвлөмж, ангийн дэг журам, аялал, сургуулийн орчин, хэл яриагаар болон бичгэн текстээр өгдөг тайлбаруудыг боломжтой бүх газарт зурган дүрслэлээр үзүүлэх хэрэгтэй. Жишээлбэл, хүүхдийн суралцахуйн үйл явц, ойлголтыг дэмжихийн тулд бодит эд зүйл, үлгэрийн уут, хүүхэлдэй, гэрэл зураг, зураг, диаграмм, чимэглэл, эд зүйл, эд өлгийн зүйлсийг ашиглах нь илүү зохимжтой.

Ахлах ангид:

Харах боломжтой байдлаар бэлтгэсэн мэдээлэл илүү зохимжтой. Хэрэв багш мэдээллийг зөвхөн хэл яриагаар дамжуулан хүргэвэл сонсголын алдагдалтай болоод бүрэн сонсголгүй хүүхдийн суралцахуйн явцад хүндрэл учирна. Тиймээс хичээлийн агуулгын түлхүүр үг, шинэ үг, суралцахуйн зорилго зэрэг чухал мэдээллүүдийг цаасан дээр бичиж бэрхшээлтэй хүүхдэд тохирсон байдлаар өгөх ёстой. Түүнчлэн гэрийн даалгаврыг зөвхөн амаар өгвөл тухайн сурагч бичиж авахад хүндрэлтэй байх тул мөн цаасан дээр бичсэн хувилбарыг хүүхдэд дагалдуулж өгөөрэй.

DVD болон дуу авианд тулгуурласан хичээлийн материал: Сонголын алдагдалтай хүүхдүүдийн хувьд бичлэг болон дуу авианд суурилсан хэлбэрээр мэдээлэл хүлээн авахад хүндрэлтэй учир агуулгыг хэвлэмэл байдлаар өгөх эсвэл бичлэг дээр хадмал тайлбар оруулах илүү өгөөжтэй байж болно.

Сонголгүй хүүхдийн төрөлх хэл бол дохионы хэл юм. Сонголгүй хүүхэд дохионы хэл сурвал тусгай нөхцөл байдал шаардахгүйгээр үе тэнгийнхэнтэйгээ ижил түвшинд суралцах бүрэн боломжтой. Харин сонголгүй хүүхдэд багаас нь дохионы хэл зааж өгөөгүй нөхцөлд хөгжлийн хоцрогдол үүсэж, цаашдаа хэвлэмэл сурах бичгүүдийг уншиж, судлах чадвар нь хязгаарлагддаг.

4.4. Сонголын бэрхшээлтэй хүүхдүүд үйлдэл хийж, түүнийгээ илэрхийлэх арга замууд

Сонголын бэрхшээлтэй хүүхэд бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг учраас багш хүн сурагчдынхаа онцлог байдалд тохируулан өөрсдийгөө илэрхийлэх олон арга замаар хангах нь зүйтэй. Бид энд дараах боломжит зарим арга замыг санал болгож байна.

Дохионы хэл ашиглах

Сонголын бэрхшээлтэй хүүхэд бүр сургуулийн өмнөх насны хүүхдээс эхлээд дохионы хэл сурч эзэмшиж, харилцааны үндсэн хэрэгслээ болгох чадвартай байдаг. Гэвч хүмүүсийн өдөр тутамдаа ашигладаг хэл ч бүс нутгийнхаа онцлогоос хамаарч харилцан адилгүй байдагтай адил дохионы хэл мөн өөр байна. Энэ нь Монгол дохионы хэл хэрэглэдэг Монгол хүн Солонгос эсвэл Орос дохионы хэлийг ойлгохгүй гэсэн үг юм. Тиймээс багш дохионы хэл сурч, сурагчтай харилцахаар шийдсэн бол бүх нийтээр хэрэглэгдэг Монгол дохионы хэл сурах нь чухал. Дохионы хэл нь хүүхдүүдийн суралцахуйн үйл явцыг дэмждэг чухал хэрэглэгдэхүүний нэг бөгөөд бүх насны хүн сурах боломжтой.

Ангийн бүх сурагчид дохионы хэлээр түлхүү хэрэглэгддэг үгсийг илэрхийлж сурснаар сонголын бэрхшээлтэй найзтайгаа төвөггүй харилцах боломж бүрдэх бөгөөд энэ нь өөрийгөө илэрхийлэх чадвар сул хүүхдүүдийн харилцааны ур чадварыг хөгжүүлэхэд асар их тус дэм болдог.

Хүүхдийн сэтгэл санааны тогтвортой байдлыг дэмжих

Багш болоод сургуулийн хүрээнд ажиллаж буй бүх хүн сонголгүй хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэнд, тогтвортой байдалд санаа тавьж, хүүхдийг тэсвэр тэвчээртэй, өөрийгөө эергээр үнэлдэг хүн болон хүмүүжих явцад хувь нэмрээ оруулах хэрэгтэй.

- Сонсголгүй сурагчид бусад хүүхдүүд ч мөн буруу сонсож, буруу ойлгож, алдаа гаргадаг гэдгийг тайлбарлан өгөөрэй. Үеийн найз нөхөд нь өөртэй нь төстэй арга туршлага, онцлог хэрэгцээтэй гэдгийг мэдэх нь тухайн хүүхдийн сэтгэл зүйд эерэгээр нөлөөлнө.
- Сонсголгүй хүүхэд өөрт нь ямар хэрэгцээ байгааг зөв илэрхийлэх, жижиг бүлгийн харилцаанд орох замаар нийгэмшлийн ур чадвараа хөгжүүлэхэд сургуулийн бусад ажилчдаас ямар дэмжлэг, туслалцаа байгааг тэдэнд илэрхийлж хэлэх боломж олгоорой.
- Сонсголгүй сурагчийг сургуулиас гадуур ямар орчин хүлээж буйг, ямар хүндрэл бэрхшээл учирч болох, асуудлыг хэрхэн шийдэж болох арга барилд сургаарай.
- Харааны хүртэхүйд зориулсан зурган илэрхийлэмж, үлгэр түүх, бусад хэрэглэгдэхүүнүүд нь бүх сурагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан үзсэн байх ёстойг анхаараарай.
- Бусад сонсголгүй том хүн, хүүхэдтэйгээ уулзах боломжоор хангах. Эцэг эх болон орон нутгийн сонсголгүй иргэдийн бүлэг үүнийг бодит болгоход тусалж болно.
- Сонсголгүй хүүхдийг мэдрэмжээ зөв “тодорхойлоход” нь туслаарай.

Хүүхдийн нийгмийн харилцааг дэмжих

Сонсголгүй хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ шууд харилцаж чаддаггүй тул бусдын өнцгөөс нөхцөл байдлыг харах, дүгнэх чадвар сул байдаг. Иймд багш тусгай багшлахуйн арга барилаар хүүхэдтэй ажиллах хэрэгцээ гарна. Ихэнхдээ сургуулийн хамгийн чимээ шуугиан ихтэй газруудад бусадтайгаа харилцах, нийгэмших боломж гардаг учраас сонсголын бэрхшээлтэй хүүхдэд хүндрэл тулгардаг. Сургуулийн дотор болон гадаа хүүхдүүд нэг нэгээрээ эсвэл жижиг бүлгийн хүрээнд харилцаа үүсгэж, нийгэмших боломжтой газар байгаа эсэхийг сайн бодолцоорой.

Сэтгэл хөдлөлийн тухай ярилцах

Ер нь ямар ч хүний хувьд нийгмийн хэм хэмжээг ойлгосноор нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх боломж бүрддэг. Сонсголтой хүүхэд амьдралын туршлагаараа дамжуулж хэм хэмжээний талаар ойлголттой болдог бол сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хувьд энэ боломж хязгаарлагдмал байдаг онцлогтой. Үүнийг харгалзаж суралцахуйн үйл явцыг зохион байгуулах нь сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж буй багшийн үүрэг хариуцлага байдаг.

Зан төлөв, бухимдлаа удирдах

Сонсголгүй хүүхэд тэсвэр хатуужилтай бөгөөд өөрийгөө эерэгээр үнэлдэг байх хэрэгтэй. Эдгээр чадварууд нь хүүхдийг тодорхой нөхцөл байдал тулгарахад

СУРГАЛТЫН ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

СУРГАЛТЫН ОРЧИН

- Дидактик орчин
- Сэтгэл зүйн орчин
- Материаллаг орчин
- Эрүүл ахуйн орчин

СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

- Сургалтын хөтөлбөр
- Лекцийн материал
- Дохионы хэлний практик хичээл, дасгалууд

АНГИ ТАНХИМ, ТОХИРУУЛГА

Сургалтын хөтөлбөрийн дагуу сэдэв тус бүрээр бэлтгэсэн лекцийн агуулга, слайд

ХУРУУНЫ ҮСГИЙН ЗУРАГТ ХУУДАС

Сургалтанд хамрагдсан багш нарт гарын авлага, хэрэглэгдэхүүн болгон өгсөн хурууны үсгийн зурагт хуудаснууд, дагалдах хэрэглэгдэхүүн



даван гарах, илүү өргөн хүрээний нийгмийн харилцаанд орсон ч хэрэгцээгээ хангах боломжийг олгодог. Харин сургуулийн зүгээс нэг талдаа тухайн хүүхдийн ялгаатай байдалд нийцүүлж тохируулга хийх, нөгөө талдаа бэрхшээлтэй хүүхдийг бусад сурагчидтай адил зан төлөвөө удирдаж, биеэ авч явахыг сануулж байх буюу тэнцвэрийг олох хэрэгтэй.

Сонсголгүй хүүхдийн зан төлөвийн тогтворгүй байдал нь дараах хүчин зүйлсээс шалтгаалан үүсэж болно.

- Эргэн тойрондоо юу болж буйг хангалттай хэмжээнд ойлгож, сонсож чадахгүй байгаадаа гутрах
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн анхаарал төвлөрөх хугацаа богино байдгийн дээр хүний яриаг сонсохын тулд анхаарлаа илүү төвлөрүүлж, оюуны ядаргаанд орох
- Бусад хүүхдүүдээс шоолж, дээрэлхсэн хандлага мэдрэх

Сургуулийн зүгээс дараах байдлаар сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эерэг зан төлөвийг дэмжих боломжтой.

- Хүүхэд дүрэм журам, тогтсон дадлыг ойлгож буй эсэхэд санаа тавих
- Цагийн хуваарь, горимд өөрчлөлт оруулах талаар тайлбарлаж, ярилцах
- Дүрэм журам, хүлээлтийг тайлбарлаж үзүүлэх бөгөөд хэрэв зөрчвөл ямар үр дүн гарахыг тайлбарлах

- Тулгарсан хүндрэл бэрхшээлийн талаар ярилцвал хүүхэд юуг буруу хийснээ ойлгоно. Сонсголгүй хүүхдүүдийн хувьд бусдын сэтгэл хөдлөл, сэтгэл зүйн байдлыг ойлгох чадвар сул байдаг тул тэсвэр хатуужлын талаар сайтар тайлбарлаж өгөх нь чухал юм.
- Хүүхдийн сонсох чадвар ямар түвшинд буй, тэдний туршлага, тулгардаг хүндрэл бэрхшээлийг ажиглах эсвэл хүүхдээс асуух байдлаар ерөнхий мэдээлэл цуглуулснаар багш тухайн хүүхдийн хөгжлийн ялгаатай байдал, онцлогт нийцүүлэн тохируулга хийх боломж бүрдэнэ.

Үнэлгээний аргачлалыг тохируулах

Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд суралцахуйн дэмжлэг үзүүлснээр тухайн хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ ижил хэмжээнд суралцаж, ахиц гаргах боломжтой бөгөөд үр дүн нь насны онцлогтой шууд холбоотой байна. Гэвч хүүхдийг үнэлэхдээ багш дараах зүйлсийг анхаарч үзээрэй.

- Тухайн хүүхэд хүний яриаг сайн ойлгодог гэдэг нь хэлний мэдлэг сайн гэсэн үг биш юм. Сонсголгүй хүүхдүүд өгөгдсөн асуулт, даалгаврыг ойлгохгүй байх тохиолдол ч байдаг.
- Зарим стандарт шалгалт нь сонсголын бэрхшээлтэй хүүхдэд тохиромжгүй байдаг. Сурагч ямар агуулгатай шалгалтыг хэрхэн өгөхөө бүрэн ойлгож байх нь чухал.
- Хүүхдийн ахицыг тогтмол тэмдэглэх хэрэгтэй. Бага насны хүүхэд бол үйл ажиллагаанд оролцож буй зургуудыг ашиглан, тэдний ахиц, амжилтыг үнэлээрэй.

ЗӨВ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙХ

Эцэг эх, асран хамгаалагчид эрт илрүүлэг, сонсголын бэрхшээл талаар болон хүүхдийнхээ талаар зөв мэдээ, мэдээлэлтэй байх

ЗӨВ ОЙЛГОЛТ, ЗЭРЭГ ХАНДЛАГА

Хүүхдийнхээ бэрхшээлийн талаар үнэн зөв ойлголт, мэдлэгтэй, зэрэг хандлагатай байх.



ДОХИОНЫ ХЭЛЭЭР ЯРИЛЦАХ

Багш, эцэг эх дохионы хэл сурч хүүхдэд зааж сургах, гэр бүл, сургалтын орчинд дохионы хэлээр тогтмол харилцах

ДОХИОНЫ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ

Багш хурууны үсэг болон дохионы хэлний анхан шатны мэдлэг эзэмшиж, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд дохионы орчин бүрдүүлж ажиллах



5

БҮЛЭГ

**ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ
СУРАЛЦАГЧИЙГ ТЭГШ
ХАМРУУЛАН СУРГАХ НЬ**

5.1. Хөдөлгөөний бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт

Хөдөлгөөнөөс үүдсэн хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдалтай холбогдох хөгжлийн бэрхшээл, тархины гэмтлээс үүдсэн бэрхшээл зэргээр олон төрлийн хөдөлгөөний бэрхшээл байна. Зарим нь хүний нүдэнд шууд харагдахуйц байхад зарим төрлийн бэрхшээл нь харагддаггүй. Аль алинд нь дэмжлэг туслалцаа шаардагдана. Хөдөлгөөний бэрхшээл нь тухайн хүний зогсох, алхах, суух, хөдлөх, эд зүйл барих чадварт нөлөөлдөг. Мөн зарим бэрхшээл хэсэг хугацаанд хүндэрч байгаад намдах зэргээр цаг хугацаанаас хамааран шинж тэмдэг нь өөрчлөгдөж болдог. Зарим тохиолдолд дэмжих болон орлуулах төхөөрөмж ашиглах шаардлага гарна (тэргэнцэр, хөлд оруулагч г.м). Зарим бэрхшээлтэй хүүхдэд ариун цэврийн өрөө орохоос эхлээд халамж туслалцаа хэрэг болдог. Харин багшийн зүгээс хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургахын тулд суралцахуйн таатай орчин бүрдүүлэх, сурагчийн суралцахуйн саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн хүртээмжтэй сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах тал дээр анхаарах хэрэгтэй.



5.2. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүдийг сэдэлжүүлэх замаар оролцоог хангах арга замууд

Хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчдын сурах сэдэл харилцан адилгүй байдаг учраас багш энэ онцлогийг харгалзаж хүүхдийг суралцах үйл явцад идэвхтэй оролцуулах олон арга замыг хичээл, сургалтын үйл ажиллагаандаа ашиглах нь зүйтэй. Энд зарим боломжит арга замыг санал болгож байна.

Ангийн орчин, зохион байгуулалт

Хөдөлгөөний бэрхшээлийн ялгаатай нөхцөл байдлаас үл хамаарч суралцагчийн оролцоог хангах суурь нь анги танхимыг суралцахад хүртээмжтэй байдлаар зохион байгуулахаас эхэлнэ. Тиймээс ангийг зохион байгуулахдаа дараах аргуудыг туршаад үзээрэй.

- Явган хүний замыг чөлөөтэй байлгах. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд анги танхимын дундуур саадгүй зорчих боломжтой байдлаар тооцоолж, хөлд тээглэх саадуудыг авч хаях хэрэгтэй. Сурагчид хөдөлж, аливаа зүйлд хүрэхэд хэн нэгний туслалцаа хэрэгтэй болж мэднэ.
- Суудлын хуваарь, зохицуулалтыг сайн бодож хийхээс гадна шаардлагатай тохиолдолд хуваарийг өөрчилж, тохируулга хийж болно. Тархины саажилттай хүүхэд биеэ удирдах чадваргүй, өөр ямар нэгэн бэрхшээл тулгарах магадлалтай тул бусад хүүхдүүдээс аль болох хол, ангийн хойно суух хандлагатай байдаг. Тиймээс эдгээр хүүхдүүдийг ангийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлээрэй.
- Хүүхэд олон давхар барилгатай сургуульд суралцдаг учир шатаар өгсөж, уруудахад хүндрэл учирвал яах вэ? Хэрэв хүүхэд дээд давхар руу гарах боломжгүй байгаа бол хүүхэд дээшээ өгсөх шаардлагагүй болтол өөрчлөлт, тохируулгуудыг хийх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл бага сургууль, цэцэрлэгийн орчинд хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн суралцдаг анги танхим сургуулийн хамгийн хүртээмжтэй хэсэгт байрлах ёстой байдаг. Дунд сургуулийн хувьд хүүхэд анги анги дамжих байдлаар хичээлдээ суух биш, багш нар цагийн хуваариа тааруулж, тухайн хүүхдийн ангид очиж хичээл заах нь илүү үр дүнтэй арга юм.

**ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫГ
ЧӨЛӨӨТЭЙ БАЙЛГАХ**

**СУУДЛЫН ХУВААРЬ,
ЗОХИЦУУЛАЛТ**

**ТЭРГЭНЦЭРТЭЙ ЗОРЧИХ
ЗАМ, ОРЦ, ГАРЦ**



Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн биед учрах бие махбодын хэрэгцээ шаардлагууд бусад хүүхдийнхээс нэлээд өөр байдаг учраас багшид энэ талаар илүү анхаарах хэрэгцээ бий болдгийг суралцахуйн үйл явцад багш бүр онцлон анхаарч байх нь чухал. Дээр дурдсан шаардлагыг хангахад чиглэсэн арга замын талаарх зөвлөмжүүдийг дор жагсаан бичлээ:

- Суралцагчийн биеийн байрлал болоод хөдөлгөөн хийх боломжтой эсэхийг анхаарч үзэх нь чухал. Тухтай орчинд хүүхдийн суралцах үйл явц идэвхэждэг. Зарим хүүхдүүд хичээлийн ширээний ард сууж чаддаггүй бөгөөд энэ нь тэдэнд тухгүй мэдрэмж төрүүлдэг.
- Шалан дээр, ширээний ард суух зэргээр өөр өөр байрлал туршиж үзэх боломж олгоорой.
- Тархины саажилттай хүүхэд удаан нэг байрлалаар суувал булчин нь хэт чангарч, өвддөг тул хэрэгцээтэй үедээ сунгалт хийж, хөдөлж байхыг зөвлөөрэй.
- Шаардлагатай тохиолдолд нэмэлт цаг өгөөрэй. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд нэг хичээлээс нөгөөд шилжих, ариун цэврийн өрөө ашиглах, эмээ уух, дасгал даалгавраа дуусгахад нэмэлт цаг хэрэгтэй бол багш тэрхүү боломжоор хангах хэрэгтэй.
- Тархины саажилттай хүүхэд гэнэт унаж татах магадлалтай тул багш бэлтгэлтэй байх хэрэгтэй. Эцэг эхтэй нь ярилцаж, шаардлагатай тохиолдолд ямар тусламж үзүүлэхээ урьдчилан мэдсэн, бэлтгэлтэй байх хэрэгтэй.
- Нийгмийн болон гэр бүлийн дэмжлэгийг бий болгоорой.
- Хүүхдийн оролцоог хангахын тулд найзын системийг бий болго. Найз нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өмнөөс тэмдэглэл хөтөлж суралцахуйн үйл явцыг нь дэмжиж өгнө.
- Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд нь бусад бэрхшээлтэй хүүхдийн адил өөрийн хүсэл сонирхол, суралцахуйн арга барилд нийцсэн сэдэв, хичээлийн агуулгад илүү идэвх санаачилгатай оролцдог. Иймд багш тухайн хүүхэдтэй болон эцэг эхтэй нь хамтран ажиллаж, хүүхдийн онцлогт тохирсон арга барилыг боловсруулаарай.

5.3. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүд сурсан мэдлэгээ олон хэлбэрээр үзүүлэх арга замууд

Хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчид мэдлэг, мэдээллийг харилцан адилгүй арга хэлбэрээр хүлээж авч, ойлгодог учир багш сурагчдыг мэдлэг эзэмших олон арга замаар хангаж ажиллах хэрэгтэй. Түгээмэл ашигладаг зарим арга замыг энд санал болгож байна.

Туслах төхөөрөмж ашиглах

Зарим сурагчид үзэг ашиглан бичиж чадахгүй байх, удаан бичих, унших явцдаа толгойгоо хяналтгүй хөдөлгөх, сургалтын орчинд байгаа хэрэглэгдэхүүнийг ашиглаж

мэдэхгүй байх зэргээр өдөр тутмын амьдралдаа хүндрэл бэрхшээлтэй тулгарч байдаг. Түүнчлэн зарим хүүхэд номын хуудас эргүүлэх, компьютер ашиглахдаа хүртэл бэрхшээлтэй тулгарч болно. Харин дэмжих төхөөрөмж, сайжруулах хэрэгслийн тусламжтайгаар эдгээр асуудлыг шийдвэрлээд зогсохгүй бусадтай адил түвшинд хүртээмжтэй боловсрол эзэмших боломж бүрдэх юм. Багш дараах туслах хэрэглэгдэхүүнүүдийг сургалтдаа ашиглах бололцоотой байдаг.

- Үзэг харандаа барихад туслах хэрэгсэл, үзэг бэхлэгч, хурууны багс
- Хүүхэд аливаа материал, эд зүйлд гараар хүрч эсвэл сонсож мэдрэх боломжийг олгодог төрөл бүрийн удирдлага, саваа, гар г.м
- Тохируулгат хайч
- Унших үйл явцыг хялбаршуулахын тулд номын тавиур, налуу ширээ ашиглах
- Хуудас эргүүлэх үйл явцыг хялбаршуулахын тулд хувцасны хавчаарыг хуудас бүрд тавих

Сургуулийн хэмжээнд эдгээр хэрэглэгдэхүүнүүд хүрэлцээтэй байдаг хэдий ч үзүүлэлт, хугацаа, хурд, хөдөлгөөний цар хүрээ болон сургалтын материал, биет заавар зөвлөмж, технологийн шаардагдах үзүүлэлтийг хангах үүднээс багш өөр боломжит сургалтын хувилбаруудыг давхар бэлтгэсэн байх ёстойг анхаарна уу.

5.4. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүд үйлдэл хийх ба илэрхийлэх арга замууд

Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг тул багш сурагчдаа өөрсдийгөө илэрхийлэх олон арга замаар хангах нь зүйтэй.

Гэрийн даалгавраа өөр хувилбараар үзүүлэх

Хүүхэд ямар хувилбараар хийсэн даалгавар болон сурсан мэдлэгээ танилцуулмаар байгааг, түүнд хэн, ямар байдлаар тусалж болохыг ярилцаж мэдээрэй. Ихэнх хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд хэл ярианы болоод суралцахуйн хэвийн хөгжилтэй байдаг тул хосоор болон бүлгээр ажиллахдаа олон төрлийн хэрэгсэл ашиглан ойлгосон мэдлэгээ танилцуулж болно. Энэ нь хүүхэд дан ганц биеийн чадамжид хязгаарлагдахгүйгээр өөрт боломжит хувилбараар оролцоогоо илэрхийлж буй хэрэг юм.

Тархины саажилттай хүүхдүүдийн ярих чадвар тааруу байдаг учраас танилцуулга хийхдээ дан ганц хэл яриагаар бус өөр ямар арга замаар үзүүлж болох вэ гэдгийг багш бодолцох хэрэгтэй. Гэхдээ тухайн хүүхдийг танилцуулга хийж чадахгүй эсвэл хийхийг хүсэхгүй байна гэж хүүхдийн өмнөөс ерөнхийлөн дүгнэж болохгүй.

Бэрхшээлтэй хүүхдэд нэмэлт цаг өгөх хэрэгтэй бөгөөд танилцуулж эхлэхэд бусад хүүхдүүд яриаг нь анхааралтай сонсож, идэвхтэй байх хэрэгтэй. Гагцхүү бүх хүүхдийн оролцоог хангахад суралцахуйн үйл явцыг чиглүүлж чадсан үед л ахиц дэвшил гарах боломжтой.

Боломжит үнэлгээний хувилбаруудыг боловсруулах

Ямар ч төрлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэхдээ багш үнэлгээний зорилгоо тодорхойлсон байх хэрэгтэй. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн хувьд биеийн хязгаарлагдмал чадамж нь хүүхдийн суралцахуйн гүйцэтгэлийг үнэлэх хэмжүүр байж болохгүй. Жишээлбэл, тоо нэмж, хасах энгийн математикийн үйлдлийг аман шалгалт хэлбэрээр эсвэл тохируулгат компьютерын гаран дээр шивэх байдлаар шалгах нь зүйтэй. Хүүхдийн хөдөлгөөний бэрхшээлийн төрөл нь тухайн хүүхдийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлдөг талаар багш тодорхой ойлголттой болсныхоо дараа хүүхдийн онцлогт тохирсон үнэлгээний зарчмыг боловсруулах нь үр дүнтэй байдаг. Жишээ болгож зарим нэг арга замыг дурдвал:

- Хүүхдүүдэд хариултаа дуу хураагуур эсвэл гар утсан дээр бичих боломж олгох
- Зарим сурагчдаас бичгийн болон аман шалгалтыг хослуулан авах нь хамгийн тохиромжтой. Хариултынхаа зураглалыг цаасан дээр буулгаж, хариултаа аман хэлбэрээр өгөх боломж бүрдэнэ гэсэн үг. Багшийн үнэлгээний зарчим тэмдэглэл болоод ярих ур чадварыг хослуулан авч үзэх хэрэгтэй.
- Бусад сурагчтай харьцуулахад удаан бичдэг хүүхдүүдэд нэмэлт цаг хуваарилж өгөх нь зүйтэй. Ялангуяа хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд шалгалтын дундуур завсарлаж, амрах хэрэгцээ гардаг учраас бэрхшээлтэй хүүхэд шалгалт өгөхдөө бусад хүүхдээс хоёр дахин их хугацаа зарцуулдаг. Тиймээс багш шалгалтыг жижиг хэсгүүдэд хуваан авах эсвэл гэрээр явж авч болно.
- Бие даан гүйцэтгэх даалгавар нь ямар нэгэн байдлаар биеийн хүч шаардсан, судалгаа хийх шаардлагатай даалгавар өгсөн бол даалгавар хүлээн авах эцсийн хугацааг сунгаж, уян хатан хандах хэрэгтэй. (номын санд суух, хол газраас мэдээлэл цуглуулах г.м)

**ЗАН ТӨЛӨВ,
НИЙГЭМШИЛ,
СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
СУРАЛЦАГЧИЙГ ТЭГШ
ХАМРУУЛАН СУРГАХ НЬ**

6

БҮЛЭГ




6.1. Зан төлөв, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт

Хүүхэд сургуулийн ажилчид болоод том хүмүүс ойлгоход төвөгтэй ааш авир гаргаж болно. Зан төлөв гэдэг нь хүүхэд өөрийгөө илэрхийлж буй харилцааны нэг хэлбэр юм. Жишээ нь хүүхэд хэл яриагаараа дамжуулж “үгүй” гэх утгыг илэрхийлж чадахгүй үедээ ширээн дээрх эд зүйлсийг түлхэх, чанга дуу авиа гаргах, гүйх зэргээр санаагаа илэрхийлэхийг зорьдог байна. Харин дунд, ахлах ангийн зан төлөвийн өөрчлөлттэй хүүхэд өөрийгөө бэрхшээлтэй хэмээн мэдрэхгүй гэсэндээ ангиас хөөгдөх гэж санаатайгаар хэрүүл маргаан дэгдээдэг байх жишээтэй.

Түүнчлэн ямар нэг сэтгэлийн шархтай бөгөөд сэтгэл хөдлөлөө илэрхийлэх нь “сул дорой” байдлын шинж тэмдэг гэж мэдэрч өссөн хүүхдүүд томчуудаас тусламж авах дургүй байдаг. Мөн сэтгэлээр унасан үедээ бусдаас тусламж дэмжлэг авдаггүй хүүхэд сандрамтгай, сэтгэл хөдлөлөө удирдах чадваргүй болдог тал бий.

Тиймээс энэхүү зөвлөмжид бэрхшээлтэй сурагчдын зайлшгүй эзэмших ёстой чадварууд болоод хүүхдийг хэрэгцээгээ эергээр илэрхийлэх чадварт сургахад багш дэмжлэг үзүүлэх арга зүйг тусгалаа.

- Хүүхэд тогтворгүй, ойлгоход төвөгтэй зан авир гаргаж байгаа бол энэ нь тухайн хүүхэд ууртай, аз жаргалгүй, стресст өртсөн байна гэдгээ илэрхийлж буй нэг арга гэж ойлгоорой.
- Хүүхдийн олон талт байдлыг харгалзан үзэж, ялгаварлан гадуурхахгүй байх, боловсролд тэгш хамрагдах боломж нөхцөлөөр хангахыг хичээгээрэй.
- Хүүхэд сэтгэл хөдлөлөө удирдан залж, хэрэгцээгээ зөвөөр илэрхийлж сурахад дэмжлэг зайлшгүй хэрэгтэй гэдгийг анхаараарай.
- Багш нар хүүхдүүдтэй эерэг, хүмүүжлийн харилцааг бий болгохыг хичээгээрэй.



6.2. Зан төлөв, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сэдэлжүүлэх замаар оролцоог хангах арга замууд

Зан төлөв, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах сэдэл нь өөр байх нь ойлгомжтой бөгөөд тэднийг сэдэлжүүлэхэд суралцах үйл явцад олон арга замаар идэвхтэй оролцуулах нь хамгийн үр дүнтэй арга болдог байна.

Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүд удаан хугацаагаар анхаарлаа төвлөрүүлж чаддаггүй бөгөөд хүүхдийн сонирхолд тулгуурлан оролцоог хангахын тулд сэдэлжүүлэх дасгалууд нэлээд хугацаагаар хийх хэрэгтэй болно. Түүнчлэн багш нар хүүхдийг хэрхэн хичээл эхлэхээс дуусах хүртэл идэвхтэй татан оролцуулж, олон төрлийн арга замаар сэдэлжүүлэх вэ гэдэгт анхаарлаа хандуулах шаардлагатай. Мөн хүүхэд багш, ангийн найз нөхөд зэрэг бусдын яриаг сонсож байхдаа анхаарлаа төвлөрүүлж сурахад дэмжлэг үзүүлбэл сайн үр дүн гарна.



• Хүүхдийн сонирхолд тулгуурлах

Зан төлөв, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээ сонирхол, арга туршлагыг танин мэдэхийн тулд багш эхлээд өөртэй нь болон эцэг эхтэй нь сайн ярилцах нь хамгийн үр дүнтэй арга байдаг.

Цэцэрлэгийн насны хүүхдийг ажиглаж, нэг үйл ажиллагаанд хэр удаан төвлөрч байгааг нь хэмжээрэй. Үр дүнд нь багш хүүхэд юунд дуртай, хэр удаан анхаарлаа төвлөрүүлж чаддаг гэх мэт хэрэгцээтэй мэдээллийг цуглуулж чадна.

Бага ангийн хүүхдийн хувьд юунд сонирхолтой байна гэдгээс гадна яг ямар төрлийн үйл ажиллагаа хүүхдийн оролцоог хангаж буйг таньж мэдэх нь чухал.

(үзүүлэх олон төрлийн арга замууд: сурагчид сонсоод өнгөрөөхөөсөө илүүтэй өөрөө хийж үзэх сонирхолтой байна уу?, үйл ажиллагаанд шууд оролцож эхлэхэд өөрийгөө бэлдэх цаг хэрэгтэй байгаа эсэх)



**ХҮҮХДИЙН ХАМГИЙН САЙН
ХӨГЖСӨН УР ЧАДВАРТ
СУУРИЛЖ ХИЧЭЭЛЭЭ ЗААХ**



**ХҮҮХДЭД ТОХИРСОН СУРАЛЦАХУЙН
ХЭВ МАЯГИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТҮҮНД
НИЙЦСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН
БАЙГУУЛАХ**

• **Өдөр тутамд хэвшүүлж мөрдүүлэх**

Бага насны хүүхэд цэцэрлэг, сургуулийн тогтсон дэг журмын талаар төдийлөн сайн ойлгодоггүй бөгөөд хүүхэд тухайн өдөр сургууль дээр юу хийхээ мэдэхгүй байж болно. Иймд өдөр тутамдаа мөрдөж хэвшсэн дадлуудаа сайтар тайлбарлаж өгвөл тухайн хүүхэд өдөрт юу хийх, яах ёстойгоо төвөггүй ойлгодог болно. Багш хичээл бүрийн эхэнд цагийн хуваарийн зурагт үзүүлэн ашиглан хүүхдүүдэд тодорхой тайлбар өгөх нь зүйтэй. Зарим хүүхдэд “одоо”, “дараа” гэсэн зурган картуудыг ашиглахад ганцаарчилсан туслалцаа хэрэг болж мэднэ.

Бага ангийн сурагчид мөн өдрийн тогтсон хэвшилтэй байх нь олон талын эерэг ач холбогдолтой юм. Багш шинэ хичээл орох бүрд цагийн хуваарийн үзүүлэнг байршуулах ба үйл ажиллагаа дуусахад хурааж, дараагийн хичээлийн цагийн хуваарийн үзүүлэнг гаргаж тавингаа сурагчидтайгаа яриа өрнүүлээрэй.

• **Хүүхдэд сонголт хийх боломж олгох**

Цэцэрлэгийн болон бага ангийн хүүхэд хүсэл сонирхолдоо хөтлөгдөн ямар үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцохоо ухамсаргүйгээр шийдэх чадвартай болсон байдаг. Тиймээс хүүхдийн оролцоог хангахын тулд багш сурагчид сонголт өгч болно. Жишээ нь нэг хичээл дуусахад дараа нь юу хийхээ хүүхдээр сонгуулж шийдэж болох юм. Сонголтын хувилбаруудаа хэлэхээс гадна сонголт хийхэд нь хэрэг болох зураг, карт ашиглан үзүүлэх боломж бий.

• **Идэвхтэй оролцоо, бүтээлч хандлага бүхий үйл ажиллагаануудыг санал болгох**

Сургуулийн өмнөх насны хүүхдүүд тоглоомд суурилсан үйлд идэвхтэй оролцдог бөгөөд практик, тоглоом, даалгаврын тусламжтайгаар суралцах үйл явц нь идэвхжиж байдаг. Тэдэнд дуу дуулах, шүлэг унших, усаар тоглох, баримлын шавраар тоглох, жүжиглэх чадваруудыг зааж өгвөл ахлах ангийн сурагчид шиг ширээний ард удаан суух шаардлага гарахгүй, хичээлд идэвхтэй оролцоно (айл гэр болж тоглох, хувцаслах г.м). Харин бага ангийн сурагчид ширээний ард 15- 20 минутаас илүү удаан суувал залхаж эхэлдэг. Тиймээс багш 15-20 минут тутамд хүүхдийн сонирхлыг

өдөөх үйл ажиллагаа явуулах эсвэл сурагчдад завсарлах хугацаа өгөөрэй. Энэ үеэр сунгалтын дасгал хийх, дуу дуулах, шүлэг унших зэргээр ангийг бүхэлд нь хамарсан үйл ажиллагаа зохион байгуулж болно.

• **Нэг үйлээс нөгөөд шилжих цаг хугацааг үр дүнтэй ашиглах**

Нэг үйл ажиллагаа дуусаад нөгөөд шилжих завсрын үед анги эмх замбараагүй байвал хүүхдийн зан төлөвт нөлөөлдөг. Иймд багш нар шилжилтийн үед ангийг хэрхэн эмх цэгцтэй байлгах талаар бодолцох хэрэгтэй. Багш хичээл дуусаж буйг амаараа хэлэх, элсэн цаг, хөгжим гэх мэт биет үзүүлэн ашиглан мэдэгдэж болно. Шилжилтийн үед багш суудал хуваарилах, даалгавар оноож өгөх зэргээр дараагийн хичээлийнхээ бэлтгэл ажлыг хийвэл үр дүнтэй байдаг.

• **Хүүхдийг магтаж, урамшуул**

Хүүхдийн сайн, зөв хийж буй үйлдлийг урамшуулан сайшаагаарай. Ялангуяа, ангидаа эерэг дулаан уур амьсгал бүрдүүлж буй хүүхдийг магтаж, дүрмээ дагахгүй байгаа сурагчдад эелдгээр сануулж хэлэх хэрэгтэй. Зарим хүүхдэд бусдын өмнө багшид магтуулах нь ичгэвтэр байдаг тул багш эрхий хуруугаа гозойлгох, мөрөн дээр нь гараа тавих зэрэг энгийн аргуудаар санаагаа ойлгуулах боломжтой.

• **Ахлах ангид хичээл заахдаа ашиглах арга зүй**

Хүүхдүүд юуг, яагаад сурч буйгаа сайтар ойлгосон цагтаа хичээлд идэвхтэй оролцох хандлагатай байдаг. Чухам ийм учраас сурагч суралцахуйн зорилгодоо хэрхэн хүрэхийг өөрөөр нь тодорхойлуулаарай. Хичээл эхлэхээс өмнө хүүхэд өнгөрсөн хугацаанд юу сурсныг товчхон дүгнээд одоо судалж буй агуулга нь ямар ач холбогдолтой болохыг тайлбарлаж өг. Ихэнхдээ хүүхдийн суралцахуйн зорилгыг багш тодорхойлдог боловч тэрхүү зорилго, зорилтдоо хэрхэн хүрэх, ямар хэрэглэгдэхүүн, дэмжлэг шаардлагатайг сурагчаар өөрөөр нь тодорхойлуулах хэрэгтэй. Ийнхүү сурагчдад сонголт өгөх нь тухайн хүүхэд биеэ даах, амжилтаараа бахархах, суралцахуйн зорилготойгоо өөрийгөө холбож ойлгох зэрэг давуу талтай. Гэсэн хэдий ч сурагчид хэр их, ямар төрлийн сонголт хийх нь тэдний онцлогоос хамаарч харилцан адилгүй байна. Багш суралцагчид сонголт хийх боломж өгөөд орхих нь хангалтгүй бөгөөд оролцоог хангахын тулд тухайн сонголтуудыг хүүхдийн бие даасан байдалтай уялдуулан анхаарч үзэх нь чухал юм. Ингэхдээ дор дурдсан зүйлүүдийг харгалзан үзээрэй гэж зөвлөж байна. Үүнд:

- Суралцагчдад дараах боломжуудыг сонгох боломж олгосноор тухайн хүүхдийн чөлөөтэй, бие даасан байдлыг дэмжиж буй хэрэг гэдгийг,
- Тулгарах бэрхшээлийн түвшнийг,
- Хүрэх үр дүн, амжилт, олонд хүлээн зөвшөөрөгдөх боломжийг,
- Ур чадварыг үнэлэхэд ашигладаг шалгууруудыг,

- Мэдээлэл цуглуулах, гүйцэтгэлд ашигладаг хэрэгслүүд,
- Өнгө, дизайн, график эсвэл зохион байгуулалт гэх мэтийг,
- Даалгаврын дэд хэсгүүдийн гүйцэтгэх дараалал эсвэл цаг хугацааг,
- Суралцагчдыг ангийн үйл ажиллагаа, хичээл даалгаврыг төлөвлөх явцад оролцох боломжоор хангахыг,
- Сурагчдыг хичээлийн ба зан төлөвийн зорилгоо тодорхойлох явцад оролцуулахыг,

• **Сурагчдыг өөрийн оролцоо болон анхаарал төвлөрөлтөө хянах арга барилд сургах**

Хүүхдэд сурах хүсэл эрмэлзлээр дүүрэн байх үедээ аливаа зүйлийг суралцахад шаардлагатай хүч хөдөлмөр, анхаарал төвлөрөлтийг өндөр түвшинд байлгахын тулд сэтгэл хөдлөл болоод анхаарлаа удирдаж эхэлдэг. Гэхдээ сурагчид ийм байдлаар өөрийгөө удирдан залах чадвар харилцан адилгүй байна. Тэдний ялгаатай байдал нь сурагчдын сурах сэдэл, чадвар чадамж, өөрийгөө удирдах чадвар, анхаарлаа төвлөрүүлэх чадварт тусгалаа олсон байдаг бөгөөд энэ бүгд хүүхдийн ахицад нөлөөлнө. Хүүхэд өөртөө зорилго тавих нь өөрийнхөө ахицыг өөрөө үнэлж, зан төлөвөө удирдах боломж олгодог аж. Гэсэн хэдий ч зорилгодоо хүрэх зам дардан биш байдаг тул сэтгэлээр унах, уур уцаартай болох үе хүүхдүүдэд тохионо. Багш сурагчийг сурах хүсэл эрмэлзлээ алдахгүй байхад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй бөгөөд заавар, сануулга, гарын авлага, товхимол, хийх зүйлсийн жагсаалт зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж өгөх нь зүйтэй. Эдгээр хэрэглэгдэхүүн нь:

- Анхаарал сарнисан үед буцаад дасгалдаа төвлөрөх хугацааг нэмэгдүүлэх,
- Уур уцаараа хянах, сэтгэл зүйн эрүүл мэндээ дэмжих зэргээр өөрийгөө удирдан зохион байгуулах,
- Хүүхдийн хичээлийн төлөвлөгөөнд өөрийгөө эргэцүүлэх, өөрийгөө “шахах” хугацаа төлөвлөх,
- Бусадтай харилцаа тогтоох, зөрчилдөөнийг шийдвэрлэх,

Боловсролын бүх түвшинд зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээг тодорхойлж, дэмжлэг үзүүлнэ гэдэг нь тэднийг анги болоод сургуулийн нэг хэсэг гэдгийг ойлгуулж, үнэ цэнийг нь мэдэрч буй гэдгээ тухайн хүүхдэд ойлгуулах явдал юм. Гэвч хүүхэд бусадтай харилцаа тогтоож, ярилцаж чадахгүй үед хүүхдийг дэмжих үйл явц удааширдаг. Бэрхшээлтэй хүүхдийг бусадтай харилцаа холбоо тогтооход тохирсон арга зүйгээр дэмжинэ гэдэг тухайн багшаас нөр их хөдөлмөр, бүтээлч сэтгэлгээ шаарддаг ажил юм. Үүнд туслах зарим боломжит арга барилууд нь:

- **Хүүхдийг эд зүйлээ бусадтай хуваалцаж сургах**

Бүх хүүхэд тоглоомоо бусадтай хуваалцах дургүй байдаг ч зарим тохиолдолд суралцахуй, харилцаа, зан төлөвийн бэрхшээлтэй хүүхэд бусдын тоглоомыг булаах, бусад хүүхдийг түлхэх, цохих зэрэг зан авир гаргадаг. Жишээ нь, тоглоомоо хуваалцах дургүй хүүхэд байвал багш тоглох явцыг удирдаж зааварчилна:

- а/ Хүүхдэд юун түрүүнд тоглоомоо хуваалцсан ч эргээд ирнэ гэдгийг тайлбарлах хэрэгтэй тоглоомыг аваад (хүүхдийн нэр)...-ийн ээлж, (хүүхдийн нэр) ээлж буюу өгөх гэж буй хүүхдийнхээ нэрийг дуудна/дуулна. Дараа нь багш тоглоомоо буцааж аваад...-ын (багшийн) ээлж, (багшийн ээлж) гэж давтан хэлнэ/дуулна. Түүний дараа тоглоомоо анх авсан хүүхдэдээ буцааж өгөөд (хүүхдийн нэр) ...-ийн ээлж, (хүүхдийн нэр) ээлж гэж хэлнэ/дуулна. Энэ дасгалаар хүүхэд тоглоомоо хуваалцсан ч эргээд ирнэ гэсэн ойлголтыг авах ёстой бөгөөд бусдыгаа хүндэлж, өөрийнхөө ээлжийг хүлээж сурдаг.
- б/ Тоглоомоо 1-3 хүнтэй хуваалцаж сургах хэрэгтэй. Эхлээд нэг хүүхэдтэй тоглоомоо хуваалцаж сурсан бол аажмаар хүүхдийн тоог нэмж жижиг бүлгийн хүрээнд тоглоомыг нь хуваалцаж сургах хэрэгтэй. Хуваалцах бүрд багш хэний ээлж вэ гэдэг зааварчилгааг өгнө.

- **Хүүхдийн сонирхолд тулгуурлаж харилцаа тогтоох**

Багш хүүхдийн хүсэл сонирхлыг олж мэдсэнээр ижил сонирхолтой хүүхэдтэй уулзуулах, хамт дасгал даалгавар ажиллах боломжийг бүрдүүлж өгнө. Жишээ нь, аутизмтай хүүхэд тодорхой сэдэв эсвэл тоглоомыг чин сэтгэлээсээ сонирхон судалдаг учир ижил төрлийн сонирхолтой хүүхэдтэй уулзвал бат бэх харилцаа холбоо тогтоож чадна.

- **Том хүн болон хүүхдийн хооронд харилцаа бий болгох**

Том хүн ба хүүхдийн хооронд харилцаа тогтоох ажлыг олон хувилбараар зохион байгуулж болно. Энд зарим арга барилыг санал болгож байна. Тухайлбал, “Чангаар гайхах” техникийг ашиглах арга байж болох юм. Хэрэв хүүхэд маш их стресст өртөж, уурлаж, мэдрэмжээ хүнтэй хуваалцахгүй байвал энэ арга үр дүнтэй. “Чангаар гайхах” үед хүүхэд ямар нэртэй сэтгэл хөдлөл мэдэрч байгаагаа ойлгох бөгөөд хажууд нь сэтгэл зүйг нь ойлгох хүн байна гэсэн санааг өгдөг. Жишээ нь, “Чи Цээгийтэй дээс тоглоё гэтэл тэр ...Үгүй ээ. Одоо... биш гэж хэлсэн учраас чамайг уурлаж байгааг ойлгож байна. Чи сэтгэлээр унасан байна..... Чи ярилцахыг хүсвэл би чамтай ярилцахад бэлэн байна” гэх мэтээр хүүхдэд хандаж ярилцахад үр дүн өгөх боломжтой.

Энэхүү техник нь бол чухамдаа хүүхдийн юу мэдэрч байгааг нэрлэж, яагаад/юу ажигласнаа хэлээд, өөрт нь хэцүү байгааг ойлгож байгаа гэдгээ хэлээд, тайвширсан үедээ ярилцах арга замыг зааж өгч буй арга барил юм.

- **Нэг нь хожиж нөгөө нь хожигдох сэдэвтэй ярианаас зайлсхийх**

Багш ялж, хүүхэд ялагдсан мэт мэдрэмж төрүүлдэг ярианаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Жишээлбэл, багш “Хэрвээ чи ийм зүйл дахиад нэг л удаа хийвэл би чамайг ингэж шийтгэнэ шүү”. Үүн шиг шийтгүүлдэг хүүхдүүд айдсаа дарахын тулд бодлогогүй алхам хийх эрсдэлтэй тул багш илүү эергээр хүүхдэд санааг ойлгуулах ёстой. Жишээ нь, “Хэрвээ чи үүнийг хийчихсэн бол хоёулаа одоо ингэж болно” гэх маягийн агуулгатай яриа бол хүүхдэд би ялагдлаа гэсэн сэтгэгдэл төрүүлэх магадлалтай гэдгийг ямагт анхаараарай.

- **Зан төлөв ба аутизм**

Аутизмтай хүүхэд ихэнхдээ хүний санамсаргүй хийсэн үйлдэлд уурлаж, сэтгэлээр унах тохиолдол элбэг байдаг. Хүүхэд түгшүүртэй болох тусам дуу нь өндөрсөж, бүдүүлэг болж, бусдыг цохих эсвэл нөхцөл байдлаас зугтаах гэж оролддог байна. Аутизмтай хүүхэд өөрийгөө удирдан чиглүүлж, зан төлөвөө хянахад багшийн зүгээс суралцахуйн орчинд юу хүүхдийн айдас түгшүүрийг төрүүлээд байна вэ гэдгийг тодорхойлох хэрэгтэй. Аутизмтай хүүхдүүд дараах бэрхшээлүүдтэй тулгарч болно. Жишээлбэл:

- Аутизмтай хүүхэд мэдрэхүйн ачаалал амархан авдаг. Аутизмтай хүүхдүүд зарим тохиолдолд дуу, хүрэлцэх, тод өнгийн гэрэл, үнэр, амтны мэдрэхүүд хэт мэдрэг байдаг. Мөн аутизмтай хүүхэд болон том хүн анхаарал сарнисан үедээ анхаарлаа төвлөрүүлэх гэж маш их хичээх шаардлага гардаг бөгөөд заримдаа өвдөлт мэдэрдэг байна.
- Аутизмтай хүүхэд эмх замбараагүй зүйлд дургүй байдаг. Аутизмтай хүүхдүүд аливаа зүйлийг жагсааж, эгнүүлж, тодорхой эмх цэгцтэй байрлалд оруулж тавих дуртай бөгөөд зурагт хуудас, дэлгэцийн байрлал тэгш бус байвал шууд стресст өртдөг. Аливаа зүйл өөрийнх нь хүлээлтэд нийцэхгүй бол мөн стресст өртдөг байна. Үүнтэй адил ангийн найз нөхөд нь дүрэм журмаа дагахгүй бол анхаарал нь сарниж, эргээд хэвэндээ орох гэж ихээхэн хүндрэлтэй тулгардаг.
- Хүнд биш аливаа зүйлд төвлөрдөг. Хүүхдүүд тодорхой нэг биет эд зүйлд анхаарал нь төвлөрдөг бол бага насны аутизмтай хүүхдийн анхаарал хаа сайгүй “тэнэж” байдаг.

Багш хүн эдгээр хүндрэл бэрхшээлээс аль болохоор сэргийлж, хэрэв хүүхэд айдас түгшүүрт автвал түүнийгээ даван гарахад нь туслах хэрэгтэй. Дэмжих арга зүй нь зөвхөн аутизмтай хүүхдэд бус ангийн бүх суралцагчдын онцлог хэрэгцээ, ялгаатай байдлыг харгалзан үзсэн байх нь илүү үр дүнтэй байдаг учраас багш хүн аль болох

нийтийн хэрэгцээг чухалчлах арга замаар суралцахуйн үйл явцыг зохион байгуулах нь чухал . Үүнд:

“Одоо” “Дараа” харьцуулсан зурагт хуудас: Цэцэрлэгийн насны хүүхдэд одоо ямар хичээл зааж буйгаа болон дараа нь ямар үйл ажиллагаа болохыг зурагт хуудсаар үзүүл. Хэрэв хүүхэд эхний сэдвийг сонирхохгүй бол хичээлийнхээ хугацааг багасгаж, хүүхдийн суралцахуйн үйл явцыг сэдэлжүүлсэн дараагийнхаа үйл ажиллагаанд анхаараарай.

- ✓ Цагийн хуваарийн үзүүлэн: Үзүүлэн ашиглаж тухайн өдөрт ямар үйл ажиллагаанууд төлөвлөгдсөнийг хүүхдэд ойлгуулаад, ярилцаарай.
- ✓ Хичээл, ямар нэг үйл ажиллагаа үргэлж дуусдаг гэдэгт хүүхдийн сэтгэл зүйг бэлтгэх: Элсэн цаг ашиглах, ангийн бусад сурагчид эд зүйлээ эмхэлж цэгцэлж эхлэх, үйл ажиллагаа дуусаж буйг мэдэгдэж цагийн хуваарийг зургаар үзүүлсэн ширээ рүү хүүхдийг хөтлөөд зургийг хураах даалгавар өгөх, ангийн сурагчдад дараа нь ямар үйл ажиллагаа төлөвлөгдсөнийг хэлэх аргуудыг ашиглаж болно.
- ✓ Биед нь тухгүй байвал заавал сурагчийн дүрэмт хувцас өмсөхийг шаардахгүй байх: Аутизмтай хүүхдүүд бие барьсан, тухгүй хувцас болоод материалд дургүй байдаг тул сургууль хүүхдийг заавал дүрэмт хувцас өмсөхийг шаардахгүйгээр уян хатан хандах хэрэгтэй. Хүүхдийг спорт өмд, үдээсгүй гутал өмсөх боломж өгснөөр тэдэнд учирч болох стрессийг бууруулж, анхаарал төвлөрөлтийг нь дэмжиж буй хэрэг юм.
- ✓ Завсарлага: Аутизмтай хүүхдийг чимээ шуугиан, гэрэл багатай орчинд завсарлах боломж олгосноор хүүхэд өөрийгөө удирдахад дөхөм болдог.

6.3. Зан төлөв, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурсан мэдлэгээ олон хэлбэрээр үзүүлэх арга замууд

Зан төлөв, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй суралцагчид бэрхшээлийн төрөл, хэмжээнээс хамаарч мэдлэг, мэдээллийг харилцан адилгүй арга хэлбэрээр хүлээж авч, ойлгодог учир багш сурагчдыг мэдээлэл авах, мэдлэг эзэмших олон арга замаар хангах шаардлагатай байдаг. Гарын авлагын энэ хэсэгт тухайн асуудлаар багшид баримжаа болох зарим арга замыг зөвлөмж болгон оруулж байна.

• Хүүхдийн хамгийн сайн хөгжсөн ур чадварт суурилж хичээлээ заагаарай

Ихэнх зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүд өөртөө итгэх итгэл сул байдаг учир өөрийгөө ичгүүртэй, сул дорой харагдуулна гэж бодсон зүйлээсээ зугтаадаг сэтгэл зүйн хандлагатай байдгийг анхаараарай. (жишээ нь унших, бичих чадвар сул бол). Нөгөөтэйгүүр зарим сурагчид өөрсдийгөө муу хүн гэж боддог бөгөөд муу хүн шиг

ааш авир гаргадаг байна. Тиймээс зан төлөвийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах үндсэн зарчим нь тэдний хамгийн сайн хөгжсөн ур чадварт түшиглэн суралцахуйн үйл явцыг нь дэмжих юм.

- **Хүүхдэд тохирсон суралцахуйн хэв маягийг тодорхойлж, түүнд нийцсэн үйл ажиллагаа зохион байгуулаарай**

Багш ангийн үйл ажиллагааг төлөвлөхдөө бэрхшээлтэй хүүхдийн давуу талыг бодолцох хэрэгтэй. Жишээлбэл, тухайн хүүхэд олон төрлөөр өөрийгөө илэрхийлж, шинэ зүйл бүтээж чаддаг уу, аливаа зүйлийг сонсоод өнгөрөхөөсөө илүүтэй өөрөө хийж үзэхдээ сонирхолтой байдаг уу гэх мэт асуудлыг аль болох оношлон танихыг хичээгээрэй.


Хэрэв хүүхдийн анхаарал төвлөрөх чадвар муу бөгөөд хичээлийн хэрэглэгдэхүүний ихэнх нь хэвлэмэл материал байвал хүүхдийн зан төлөв тогтворгүй болж ирдэг. Зөвхөн хэвлэмэл байдлаар агуулга сэдвийг хүргэж, үр дүнг тайлбарлах нь өрөөсгөл бөгөөд ялангуяа хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд тохирсон арга биш юм. Иймд багш хичээлээ олон төрлийн үзүүлэх аргуудыг ашиглан заах нь үр дүнтэй.

Жишээ нь гол санаагаа тэмдэгтүүдээр дүрслэх бөгөөд (жишээ нь тайлбар текст эсвэл математикийн тэгшитгэл) сурагчдын онцлог хэрэгцээнд тохируулан олон хэлбэрээр хүргэж болно (жишээ нь, дүрслэл, бүжиг/хөдөлгөөн, диаграмм, ширээ, загвар, видео, комик стрип, үлгэрийн самбар, гэрэл зураг, хөдөлгөөнт дүрс). Сурагч мөн өөрийн сонирхсон хувилбарыг бүтээж болно.

6.4. Зан төлөв, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхдүүд үйлдэл хийж, түүнийгээ илэрхийлэх арга замууд

Зан төлөв, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхэд бүр өөр өөрийн онцлог байдалдаа тохирсон ялгаатай арга арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг учраас багш сурагчдадаа суралцах болон өөрсдийгөө илэрхийлэх олон арга зам бүхий боломжийг хангаж ажиллах учиртай. Бид гарын авлагынхаа эл хэсэгт багшид энэ талаар тус болох зарим боломжтой арга замыг санал болгож байна.

Зан үйлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрсдийн сонирхол, ур чадварт тохирсон арга замаар өөрийгөө илэрхийлэх үед зан ааш нь тогтвортой байдаг. Энэ өвөрмөц байдлыг нь харгалзан суралцахуйн үйл явцыг зохион байгуулах нь багшийн ажилд ихээхэн тустай байх болно. Үүнд дараах арга замуудыг ашиглах нь үр дүнтэй болохыг зөвлөө.



• **Олон хэлбэрээр илэрхийлэх арга зүйг ашиглах**

Энэхүү арга зүй нь дан ганц зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдэд биш ерөнхийдөө харилцааны бэрхшээлтэй хүүхдүүдэд тохирдог арга зүй юм. Жишээлбэл, бүх суралцагчид бичих чадварт суралцахаас илүүтэй найруулан бичих чадварт давхар суралцах нь зүйтэй.

Тодорхой нөхцөл байдлыг харгалзан тооцож багш нар хүүхдүүдэд янз бүрийн хэлбэрээр суралцахуйн үйл явцаа төлөвлөж, бүтээх боломж олгоорой. Үүнд:

- Текст, яриа, зураг, чимэглэл, дизайн, кино, хөгжим, бүжиг/хөдөлгөөн, дүрслэх урлаг, уран баримал, видео гэх мэт олон төрлийн арга хэрэглэх
- Биет үзүүлэн дээр ажиллах (*жишээ нь блок, 3D загвар, үндсэн арван блок*)
- Текст, яриа, зураг, чимэглэл, комикс, үлгэрийн самбар, дизайн, кино, хөгжим, дүрслэх урлаг, уран баримал, видео гэх мэт олон төрлийн арга хэрэглэх

• **Сурагч сурлагын ахицаа өөрөө үнэлэх чадварт сургах**

Суралцагч багшаасаа санал зөвлөмж сонсохгүйгээр жинхэнэ утгаараа суралцах боломжгүй бөгөөд ахиц гаргаж буй эсэхээ нарийн хэмжих нь чухал ач холбогдолтой. Багш тохирсон арга барилаар, тогтмол хугацаанд хүүхдийн ахицыг үнэлэхгүй бол сурагчийн суралцахуйн үйл явц зогсонги байдалд ордог. Сурагч юуг засаж сайжруулахаа мэдэхгүй бол хичээлдээ идэвхгүй хандаж эхэлдэг бөгөөд бэрхшээлтэй хүүхдүүдийн ахицыг тогтмол, хүүхдүүдийн ахицыг тодорхой хугацаанд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хэмжиж, санал зөвлөмж өгөх нь маш чухал үйл явц юм. Ялангуяа багш ахицын үнэлгээний үр дүнд суурилсан заавар зөвлөмжийг сурагчдад тогтмол өгч байх хэрэгтэй бөгөөд сурагч сурлагын ахицаа өөрөө үнэлж сурах нь ихээхэн ач холбогдолтой.

• **Багш нарын хувьд:**

- Өөрийнхөө ахицыг хэмжих, эргэцүүлэн бодоход чиглүүлсэн асуулт асуух
- Ахицыг дүрслэн харуулах (жишээ нь өмнө болон дараах зураг, тодорхой цаг хугацаанд гарсан ахиц дэвшлийг харуулсан график, үйл явцын багц зураг)
- Суралцагчдаас ямар төрлийн санал хүсэлт авах хүсэлтэй байгааг сонсож, тодорхойлох
- Чанар болон гүйцэтгэлийг хэмжихдээ загвар ашиглах
- Өөрийгөө үнэлэх стратегийн ялгаатай загваруудаар хангах (жишээ нь, дүрд тоглох, видео тойм, үе тэнгийнхний санал хүсэлт)
- Үнэлгээний хяналтын хуудас, онооны хүснэгт, сурагчийн гүйцэтгэлийг хэмжих олон төрлийн жишээ ашиглах зэрэг олон арга замыг ашиглаж суралцагчдад өөрсдийг үнэлэх боломж олгохыг хичээгээрэй.

• **Багшийн үнэлгээ болон санал зөвлөмж нь гүйцэтгэлээс гадна хүүхдийн хичээл зүтгэлийг давхар харгалзан үзсэн байх**

Хүүхэд тухайн бэрхшээлийг тогтсон хэв шинжтэй, өөрчлөгдөх боломжгүй гэж үзэж байгаа тохиолдолд өөрийнхөө ур чадварт итгэх итгэл сул байдаг бөгөөд өөрийгөө хэзээ ч өөрчлөгдөхгүй гэж бат итгэсэн байдаг. Багш ийм төрлийн хүүхдийг үнэлэхдээ ур чадварт суурилсан үнэлгээний аргачлалыг ашиглана. Энэ нь хүүхдийн гүйцэтгэл эсвэл зохицлын талаар тогтсон ойлголтод ач холбогдол өгөхөөс илүүтэй суралцагчийг ур чадварын талаас нь чиглүүлж, дэмжиж байдаг үнэлгээний төрөл юм. Энэ арга нь сурагч урт хугацааны зорилгодоо хүрэх, суралцахуйн дадлага туршлага эзэмшихэд тухайн хүүхдийн “оюун ухааны чадамж”, “байгалийн өгөгдөл” гэхээсээ илүүтэй гаргаж буй хичээл зүтгэлийг гол хүчин зүйл гэж авч үздэг.

• **Багш сурагчдад санал зөвлөмж өгөхдөө:**

- Санал зөвлөмж нь тэсвэр хатуужилтай байхыг уриалсан, үр дүн, өөрийгөө танин мэдэх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн байхын сацуу бэрхшээл сорилттой тулгарахад тодорхой дэмжлэг, стратеги ашиглахыг зөвлөсөн байна.
- Гүйцэтгэлээс илүүтэй хичээл зүтгэл, сайжруулалт, ололт амжилтыг харгалзан үздэг
- Санал зөвлөмжийг тогтсон хугацаанд, ойр ойрхон, тодорхой өгөх
- Харьцуулсан, өрсөлдүүлсэн биш илүү бодитой, мэдээллийн чанартай санал зөвлөмж өгөх
- Багш сурагчийг юун дээр голчлон алдаж буйг нь тодорхойлж, үнэлгээний хэсэгт тусгах ба уг үнэлгээг ирээдүйн зорилгодоо хүрэх эерэг стратегидаа хэрхэн тусгаж болохыг загварчилсан байна
- Хэрэв хүүхэд “Би чадахгүй байна” гэж хэлбэл багш “Чи одоохондоо л чадахгүй байгаа юм” хэмээн тодотгох гэх мэт.



7

БҮЛЭГ

**СУРАЛЦАХУЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
СУРАЛЦАГЧИЙГ
ТЭГШ ХАМРУУЛАН
СУРГАХ НЬ**

7.1. Суралцахуйн бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт

Суралцахуйн бэрхшээл гэдэг нь сурагчийг үеийн хүүхдүүдтэйгээ ижил түвшинд ур чадвар, мэдлэг боловсрол эзэмшихэд саад болж буй нөхцөлийг хэлдэг. Хүүхдүүд ой тогтоолт, анхаарал төвлөрөлтийн зэрэг танин мэдэхүйн бэрхшээлтэй байж болно. Багш харилцааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохируулж хичээлээ заах хэдий ч хүүхдийн сурах боломжийг хязгаарладаг энэхүү нөхцөл байдал арилдаггүй. Энэ нь хүүхдийн унших, бичих, үсэглэх чадварт сөргөөр нөлөөлөөд зогсохгүй сэдвийг гүнзгийрүүлэн судлах, суралцах, амжилтад хүрэх үйл явцад мөн нөлөөлдөг. Зарим хүүхдүүдийн хувьд үе тэнгийнхнээсээ хөгжлийн хоцрогдолтой байгаадаа бухимдаж, урам хугардаг тул зан төлөвийн бэрхшээлтэй хавсрах эрсдэлийг нэмэгдүүлдэг ажээ.

Түүнчлэн, үе тэнгийнхний гадуурхалт, өөртөө итгэл муутай байдал нь тухайн хүүхдийн амжилтад хүрэх чадварыг улам бүр дарангуйлж байдаг. Иймд дан ганц суралцахуйн бэрхшээлийн сөрөг талд ач холбогдол өгөхөөс илүүтэй хүүхдийн давуу талыг мөн онцолж, онцлог хэрэгцээг нь таньж, өөрийгөө эергээр үнэлэх үнэлэмж бий болгоход сургуулийн зүгээс хэрхэн дэмжих тал дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй.



7.2. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүдийг сэдэлжүүлэх замаар оролцоог хангах арга замууд

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сурах сэдэл олон хүчин зүйлийн улмаас харилцан адилгүй байдгийг өмнөх бүлгүүдэд авч үзсэн билээ. Үүнтэй нэгэн адилаар суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийн хувьд суралцахуйд учирч буй бэрхшээлээсээ хамаараад суралцах сэдэл нь өөр өөр байх учир багш тухайн хүүхдийг суралцах үйл явцад идэвхтэй оролцуулахдаа олон арга замыг эрэлхийлэх нь зүйтэй.

- **Хүүхдийн сонирхол, чадвар чадамжид тулгуурла**

Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүд юуг, хэрхэн сонирхох нь хүүхдийн онцлогоос шалтгаалж өөр байх тул багш тухайн хүүхдийн сонирхолд нийцсэн байдлаар арга



барилаа өөрчлөх хэрэгтэй. Зарим сурагчид шинэ, шинэлэг санаачилгад дуртай байдаг бол бусад нь тогтсон хэв загвараар суралцахыг илүүд үздэг. Үүнтэй адил зарим сурагч ганцаараа хичээллэхийг илүүд үздэг бол бусад нь багийн ажилд идэвх, санаачилгатай оролцдог байх жишээтэй. Мэдээж бүх суралцагчийн нөхцөл байдалд тохирсон тэдний оролцоог хангах тогтсон оновчтой загвар гэж үгүй (CAST, 2013). Харин багш хүүхдийнхээ хэрэгцээ сонирхлыг танин мэдэж, өөртэй нь болоод эцэг эхтэй нь ярилцах нь хамгийн үр дүнтэй арга юм.

Хүүхдүүд илүүтэй сэтгэлийг нь хөдөлгөсөн хичээлд идэвхтэй оролцож, сэтгэгдлээ хуваалцаж, асуулт асуух нь олонтоо. Иймд хүүхдийн дуртай номыг нь дахин унших боломж олгоорой. Хүүхдүүд уншиж сурахаасаа өмнө үлгэр, түүх олон дахин сонсож, харилцан ярианд өөрийгөө дасгах сонирхол өндөр байдаг. Хүүхэд өөрөө хийхийг хүссэн болон төлөвлөсний дагуу бүлгийн ажлын хүрээнд хүүхдүүдтэй хамт дуу дуулж, шүлэг уншаарай. Эд зүйл, хүүхэлдэй гэх мэт биет үзүүлэн ашиглан ярьж буй түүх, дуулж буй дуугаа илүү бодитой, сонирхолтой болгож болох бөгөөд хүүхдийн суралцах үйл явцыг бодит үйлдлээрээ дэмжих нь чухал.

- **Биеэрээ оролцох боломжтой үйл ажиллагаа санал болгох**

Сургуулийн өмнөх насны хүүхдүүд тоглоомд суурилсан үйлд идэвхтэй оролцдог бөгөөд практик тоглоом, даалгаврын тусламжтайгаар суралцах үйл явц нь идэвхжиж байдаг. Тэдэнд дуу дуулах, шүлэг унших, усаар тоглох, баримлын шавраар тоглох, жүжиглэх чадваруудыг зааж өгвөл ахлах ангийн сурагчид шиг ширээний ард удаан суух шаардлагагүй, хичээлд идэвхтэй оролцоно. (айл гэр болж тоглох, хувцаслах г.м) Харин бага ангийн сурагчид ширээний ард 15-20 минутаас удаан суувал залхаж эхэлдэг. Тиймээс багш 15-20 минут тутамд хүүхдийн сонирхлыг өдөөх үйл ажиллагаа явуулах эсвэл сурагчдад завсарлах хугацаа өгөөрэй. Энэ үеэр сунгалтын дасгал, дуу дуулах, шүлэг унших зэргээр ангийг бүхэлд нь хамарсан үйл ажиллагаа зохион байгуулж болно.



- **Олон мэдрэхүйг зэрэг ашиглах замаар суралцах, суралцахуйн үйл явцыг хөгжилтэй байдлаар хөтлөн явуулах**

Бүх суралцагчийг мэдээлэл хүлээн авах тэгш боломжоор хангахын тулд мэдээллийг олон мэдрэхүйгээр зэрэг дамжуулан хүргэх нь чухал. Хүүхэд хүрэлцэхүй, сонсголын, харааны, амтлах, үнэрлэх мэдрэхүйг ашиглах замаар хүлээн авсан мэдээллээ төвөггүй эргэн санадаг. Энэ төрлийн суралцахуйн үйл явц нь сурагчдыг нэгээс илүү мэдрэхүйгээ ашиглаж суралцахуйг дэмждэг тул олон мэдрэхүйг зэрэг ашиглах замаар суралцах гэж нэрлэдэг. Жишээ нь:

- Бүх зураг, график, бичлэг, хөдөлгөөнт дүрсийг текстээр эсвэл аман яриагаар тайлбарлах
- Гол санаагаа илэрхийлэхийн тулд бодит эд зүйл эсвэл брайл график ашиглах
- Цэцэрлэгийн насны хүүхдүүдэд зориулсан “шидэт уут” хийгээрэй. Багш нь уутанд эд зүйлс хийх бөгөөд хүүхэд тухайн эд зүйлийг мэдэрснээр юу болохыг нь таах

- **Баримлын шавар, хуванцар савнаас ус цацрах гэх мэт хүрэлцэх мэдрэмжээр дамжуулан үсгийн хэлбэрийг нүдлүүлэх**

Өдөр тутамдаа хэвшүүлж мөрдүүлэх алхмуудыг сайн хэвшүүлэх нь чухал. Бага насны хүүхэд цэцэрлэг, сургуулийн тогтсон дэг журмын талаар төдийлөн сайн ойлгодоггүй бөгөөд хүүхдэд тухайн өдөр сургууль дээр ирээд юу хийхээ мэдэхгүй байж болно. Иймд өдөр тутамдаа мөрдөж хэвшсэн дадлуудаа сайтар тайлбарлан өгвөл тухайн хүүхэд өдөрт юу хийх, яах ёстойгоо төвөггүй ойлгодог болно. Багш хичээл бүрийн эхэнд цагийн хуваарийн зурагт үзүүлэн ашиглан хүүхдүүдэд тодорхой тайлбар өгөх нь зүйтэй. Зарим хүүхдэд “одоо”, “дараа” гэсэн зурган картуудыг ашиглахад ганцаарчилсан туслалцаа хэрэг болж мэднэ.

Бага ангийн сурагчид мөн өдрийн тогтсон хэвшилтэй байх нь олон талын эерэг нөлөөтэй. Сурагчдад шинэ агуулга орох бүрд цагийн хуваарийн үзүүлэнг байршуулах ба үйл ажиллагаа дуусахад хурааж, дараагийн хичээлийн цагийн хуваарийн үзүүлэнг гаргаж тавингаа яриа өрнүүлээрэй.

- **Бие даалтыг олон янзаар гүйцэтгэх сонголт өгөөрэй**

Сурагчид хийсэн даалгавраа олон хэлбэрээр танилцуулж болно. Жишээ нь сурагч бие даалтаа ганцаараа хийх эсвэл бүлгээр хамтарч ажиллах;

Бие даалтаа ямар байдлаар танилцуулах боломжтой байгаагаа сонгож болно. Жишээ нь өөрийн түүхээ компьютер дээр шивэх эсвэл гараар бичих, ангийнхаа найзтайгаа хамтран богино бичлэг хийх эсвэл цаасан дээр бичих, богино хэмжээний жүжигчилсэн тоглолт бэлдэх эсвэл танилцуулга бэлдэх, сэдвээ жагсаалт дотроос сонгох-шинжлэх ухааны хичээл дээр судлах, тайлан бичих агуулгатайгаа холбоотой сэдэв сонгох /жишээ нь цаг агаар/ г.м

- **Нэг үйлээс нөгөөд шилжих цаг хугацааг үр дүнтэй ашиглах**

Нэг үйл ажиллагаа дуусаад нөгөөд шилжих завсрын үед анги эмх замбараагүй байвал хүүхдийн зан төлөвт нөлөөлдөг. Иймд багш нар шилжилтийн үед ангийг хэрхэн зохион байгуулахаа бодолцох хэрэгтэй. Багш хичээл дуусаж буйг хэлэх, элсэн цаг, хөгжим гэх мэтээр биет үзүүлэн ашиглан мэдэгдэж болно. Шилжилтийн үед багш суудал хуваарилах, даалгавар оноож өгөх зэргээр дараагийн үйл ажиллагаандаа бэлдэж болно.

- **Хүүхдийг магтаж, урамшуулаарай**

Хүүхдийн сайн, зөв хийж буй үйлдлийг сайшаа. Ялангуяа ангидаа эерэг дулаан уур амьсгал бүрдүүлж буй хүүхдийг магтаж, дүрмээ дагахгүй байгаа сурагчдад эелдгээр сануулж хэлэх хэрэгтэй. Энэхүү арга нь бүх хүүхдэд тохирдог. Зарим хүүхдэд бусдын өмнө багшид магтуулах нь ичгэвтэр байдаг тул багш эрхий хуруугаа гозойлгох, мөрөн дээр нь гараа тавих зэрэг энгийн аргуудаар санаагаа ойлгуулж болно.

- **Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх үйл явцад нь дэмжлэг үзүүлээрэй**

Хүүхэд өөрийнхөө хичээлийг хийж дууссаны дараа тусгай хэрэгцээт найддаа тусалж, суралцахуйн үйл явцад нь дэмжлэг үзүүлж болно. Бие биедээ тусалснаар бэрхшээлтэй хүүхэд болоод ангийн нөхөд хамтдаа суралцаж, хөгждөг. Үүнийг “үе тэнгийн хүүхэд нь багшлах” арга барил гэж нэрлэдэг. Гэхдээ энэ нь бэрхшээлтэй хүүхдэд зөвхөн ангийн найз нөхөд нь л туслах ёстой гэсэн санаа биш юм. Тиймээс суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд юунд дуртай, ямар ур чадвартайг сайтар судалж, сонирхол дээр нь үндэслэн суралцахуйн үйл явцыг нь дэмжих нь чухал юм.

7.3 Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүд сурсан мэдлэгээ олон хэлбэрээр үзүүлэх арга замууд

Суралцахуйн бэрхшээлтэй суралцагчид мэдээллийг харилцан адилгүй хүлээж авч, ойлгодгийн зэрэгцээ бас сурсан мэдсэнээ илэрхийлэн үзүүлэх арга хэлбэрийн хувьд өөр хоорондоо болон бусад хүүхэдтэй харьцуулахад нэлээд ялгаатай байдаг учир багш сурагчдыг мэдлэг эзэмших олон арга замаар хангах хэрэгтэй. Зарим нэг арга замыг энд зөвлөмж болгож байна.

- **Текстийг хялбаршуулах**

Текстийн унших түвшнийг хялбаршуулснаар (жишээлбэл, үгийн тоог цөөлөх, мэддэг үг ашиглах, энгийн дүрмээр, өргөн хэрэглээний хэлц ашиглах) сэдвийн гол санааг хүртээмжтэй ойлгоход тусалдаг. Энэ арга нь ялангуяа оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой бөгөөд үе тэнгийнхэнтэйгээ ижил агуулга судлах ч хүүхдийн онцлогт тохируулж хялбаршуулсан байдаг нь давуу талтай.



- **Зураг, график, эд зүйлс, бичлэг ашиглах**

Хүүхэд зурагт үзүүлэнгийн тусламжтай түлхүүр үг, үйл явц, үлгэр түүхийг төвөггүй ойлгох боломжтой байдаг учраас суралцахуйн бэрхшээлтэй хүүхдэд боломжтой нөхцөлд нь зурагт үзүүлэн, график дүрслэл зэргийг ашиглах нь ихээхэн үр дүнтэй байдаг.

- **Хүүхдийн үгийн санг баяжуулах**

Суралцагчид аливаа сэдвийг заахдаа тухайн сэдэвтэй холбоотой хүүхдийн өмнөх мэдлэг ойлголт дээр нь тулгуурлан заавал үр дүнгээ өгдөг аж. Зарим сурагчид багшийн заах гэж буй сэдвийн талаар ямар ч ойлголтгүй байж мэднэ эсвэл

ойлголттой ч шинээр заах сэдэвтэй хэрхэн уялдахыг мэдэхгүй байж болно. Тиймээс өмнөх мэдлэгийг сэргээж, танин мэдэхүйг нь идэвхжүүлэх, эсвэл шинээр зааж буй сэдэв нь өмнөх мэдлэгтэй нь хэрхэн холбогдохыг тайлбарлаж өгөх зэргээр хүүхдийн суралцахуйг олон янзаар дэмжиж болно.

Нэмэлт аргуудыг дурдвал:

Хүүхдийн өмнөх мэдлэгийг сэргээхийн тулд утгын зураглал хийх хэрэгтэй.

Тухайн ангид суралцаж буй сурагчдыг баг болгон хувааж судлах гэж буй хичээлийн сэдвийн талаар а) юу мэдэх, б) юуг мэдмээр байна, в) хичээлийн төгсгөлд юу сурснаа эргэж дүгнэж, ярилцах гэсэн гурван төрлийн даалгавар өгөөрэй. Сурагч сэдвийн талаар юу мэдэж буйгаа заавал хэл яриагаа илэрхийлэх шаардлагагүй бөгөөд цаасыг гурван багана болгон нугалаад дээр нь зурах эсвэл утгын зураглал хийж болох юм. Мөн бичих чадварт сайн суралцагчаар бүлгээ төлөөлж, санаагаа ярилцан бичүүлэх боломж бий.

Сурагчдад ойлгуулах ёстой гол санаагаа урьдчилан бэлд Багш нар аливаа сэдвийн агуулгаас зайлшгүй зурах ёстой гол санаа болоод, санаагаа сурагчдад хүргэх олон төрлийн арга замыг тодорхойлох нь зүйтэй (жишээ нь аудио ном, диаграмм үзүүлэн, YouTube-ийн бичлэг, харьцуулалт эсвэл зүйрлэл). Ийнхүү тодорхойлсон агуулгаа хүүхдийн эцэг эхтэй хуваалцвал тухайн хүүхэд гэртээ мөн суралцах боломж бүрдэнэ.

7.4. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүд үйлдэл хийж, түүнийгээ илэрхийлэх арга замууд

Хүүхэд бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг тул багш сурагчдаа өөрсдийгөө илэрхийлэх олон арга замаар хангах нь зүйтэй.

- ✓ Бод-Хамтар-Хуваалц аргачлалыг ашиглах
- ✓ Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийг ангийн найзтай нь хослуулж, хамт сургах хэрэгтэй.
- ✓ Багш хичээлийн сэдэвтэй холбоотой асуулт асуухад хүүхэд бүр дотроо зөв хариулт юу байж болохыг бодно (Бодох);
- ✓ Хосоороо сууж байгаа сурагчид хоорондоо аль нь зөв хариулт болохыг ярилцана (Хамтар)
- ✓ Ангийн нөхөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зөв хариултаа бичихэд нь туслах эсвэл хоорондоо ярилцаад зөв гэж үзсэн асуултаа цаасан дээр бичнэ (Хуваалц).
- ✓ Эсвэл багш асуусан асуулттайгаа холбоотой хариултаа зургаар үзүүлж болох бөгөөд сурагчид зөв гэж бодсон хариулттай холбогдох зургийг сонгож болно.

Үнэлгээний аргачлалыг хүүхдийн ур чадварт нийцүүлж тохируулах

Багш хүүхдийн ахицыг тогтмол ажиглаж, тэмдэглэж байхаас гадна, үнэлгээний аргачлалыг тухайн хүүхдэд хүртээмжтэй байдлаар тохируулж болно. Хүүхэд сурсан мэдлэг ойлголтоо илэрхийлэхэд дараах 4 хүчин зүйл саад болж байдаг бөгөөд багш эдгээрийг анхааран авч үзэх ёстой.

1. Үзүүлэх арга барил

Багш нар чиглэл, заавар, мэдээ мэдээллийг хүргэх арга барилаа өөрчилж болно. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд унших, сонсох зэргээр харааны болон сонсголын мэдрэхүйгээр мэдээлэл хүлээн авахаас илүүтэй, мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр эзэмших өөр бусад аргуудыг ашиглах боломж бүрдэнэ гэсэн үг юм. Харилцааны бэрхшээлтэй хүүхдийн хувьд чухал мэдээллийг тодруулах, дасгал даалгаврыг харахад ойлгомжтой болгох, багшийн хэлсэн энгийн зааварчилгааг ашиглах зэргээр тохируулга хийж болно.

2. Хариу үйлдэл

Сурагч сурсан мэдлэгээ зөвхөн аман яригаар илэрхийлж танилцуулах хэрэгцээг багасгах нь зүйтэй. Түүний оронд өөр бусад үнэлгээний аргачлалыг туршиж болно. Жишээ нь компьютер дээр шивэх, гол санааг дугуйлах эсвэл заах, математикийн хичээлийн хариуг тооны машин дээр үзүүлэх эсвэл 1-100 хүртэлх тооны үзүүлэн дээр зааж болно.

Санаагаа зураглах буюу цэгцтэй бодож сэтгэх дасгалаар дамжуулж хүүхэд оюун бодлоо цэгцлэх боломжтой.

3. Зохион байгуулалт

Багш хүүхдийн мэдлэг чадварыг хамгийн боломжит байдлаар үнэлэхэд ямар зохион байгуулалтууд шаардагдах вэ гэдгийг сайтар бодолцох хэрэгтэй. Жишээ нь аутизмтай хүүхдүүд хэт их чимээ, тод гэрэл, хурц үнэрт анхаарал нь сарнидаг тул гал тогоотой ойр биш чимээгүй орчинд шалгалтаа өгөх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй юм.

4. Хугацаа

Энэ нь сурагчдад шалгалт, даалгавраа дуусгах нэмэлт хугацаа өгөх, их даалгаврыг жижиг хэсгүүдэд хуваах, ойлгохгүй тохиолдолд заавар чиглүүлэг авах, өдрийн тодорхой цагт шалгалт авах зэрэг цаг хугацаатай холбоотой тохируулгууд багтана.

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛД ХАМААРАХ ХУУЛЬ ЭРХЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлал” / Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/155 дугаар тушаал/ А/155 2018/12
2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар” / ХНХ, БСШУС, ЭМ-ийн сайдын 2018 оны А/304, А/699, А/460 дугаар тушаал/ А/304, А/699, А/460/ 2018
3. “Дээд боловсролын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох нөхцөлийг хангах тухай” /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/261 дүгээр тушаал/ А/261 2018
4. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам” /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаал/ А/292 2019
5. “Хэл ярианы хөгжил” сургалтын жишиг хөтөлбөр /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/305 дугаар тушаал/ А/305 2020
6. “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам” / Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/184 дүгээр тушаал/ А/184 2020
7. “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл” /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/249 дүгээр тушаал/ А/249 2020
8. “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар” /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/296 дугаар тушаал/ А/296 2020
9. “Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бага, дунд ангийн сургалтын төлөвлөгөө”, “Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хүүхдийн сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөө”, “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”,
10. “Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө” /Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/37 дугаар тушаал/ А/37 2020

11. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам” /Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/177 дугаар тушаал/ А/177 2021
12. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр суралцаж буй суралцагчийг үнэлэх чиглэл / Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/325 дугаар тушаал/ А/325 2021
13. Харааны бэрхшээлтэй хүүхдэд гэр ахуйн баримжаа олгох сургалтын жишиг хөтөлбөр / Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Сургалтын хөтөлбөр батлах тухай” А/309 дүгээр тушаал/
14. <https://online.pubhtml5.com/pacj/orsr/#p=1>

Тэмдэглэл

